

МОНГОЛ УЛСЫН ЗГМ ШИЛДЭГ СОНИН



ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

2018.01.23, БААСАН ~ №040 (839)

~ СОЁЛТ ХҮНИЙ ӨГЛӨӨ СОНИН УНШИХААС ЭХЭЛДЭГ ~

ҮНЭ: 1000₮

15-49 насныхны 48 хувь нь жингийн илүүдэлтэй

Монголчууд таргалалтаас гадна амин дэмийн дутагдалд өртөж байна. > 6

1072 ширхэг хувьцаа энэ онд амилах нь эргэлзээтэй

Гадаадын хөрөнгийн биржийн шаардлага хангаж байж хөрөнгө оруулагчаа олох ёстой. > 11

FT FINANCIAL TIMES

- Эрүүл мэндийн үйлчилгээнд хувийн хэвшил давамгайлах болов
- Alibaba-гийн зээлжих зэрэглэлд итгэхгүй байна

ZGM DAILY

Respiratory diseases alarmingly increased in UB

Report on Mongolia's air pollution crisis released. > 7

ОНЦЛОХ

УЛС ТӨР
Нийслэлийн харьяа
 байгууллагуудыг Яармаг орчимд шилжүүлэх шийдвэрийг ЗГ-аас гаргалаа.
Монгол, Оросын Засгийн газар
 хоорондын хуралдаан энэ сард Москва хотноо болно.
УБТЗ нийгэмлэгийн төлсөн
 онцгой албан татварын асуудлыг УИХ шийднэ.
Засгийн газар: "Эдийн засгийг сэргээх хөтөлбөр" үр дүнгээ өгч байна.

ЭДИЙН ЗАСАГ
 Гадаад валютын улсын албан нөөц гурван тэрбум ам.долларт хүрэв.
Ипотекийн зээлд он
 гарсаар 497 иргэн хамрагдаж, нийт зээлдэгч 93 мянгад хүрэв.
Төлбөрийн тэнцэл 1.4 тэрбум
 ам.долларын ашигтай гарсныг Монголбанкнаас мэдээллээ.
"Баян Тээг" компани нэгж
 хувьцаандаа 100 төгрөгийн ногдол ашиг хуваарилна.
ТОП-20 индекс 20001.38 нэгж
 болж, 3.38 хувиар буурав.



НИЙГЭМ
"Сити-тур" аяллын автобус
 ирэх тавдугаар сарын 1-нээс явж эхэлнэ.
Хүн ам, орон сууцны ээлжит
 тооллого 2020 оны нэгдүгээр сард явагдана.
Агаарын бохирдолтой дүүрэгт
 амьдардаг хүүхдүүдийн уушгины багтаамж бага байгааг тогтоожээ.
Таван өрх тутмын нэгд нь
 хүнсний баталгаат байдал алдагдсан байна.

ДЭЛХИЙ
Пентагон Швейцарт
 пуужингаас хамгаалах Patriot систем байршуулаа.
Венесуэл алтан баталгаат
 криптовалют гүйлгээнд нэвтрүүлж буйгаа зарлав.
Фүкүшимагийн сүйрсэн
 цөмийн реакторын дээр шинэ дээвэр байгуулав.
Хятадын хөлөг Умард Солонгост
 тавьсан хоригийг зөрчсөн эсэхийг Бээжин шалгахаар боллоо.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР
 2018.02.23

-11° | **-24°**

БАГАВТАР ҮҮЛТЭЙ

ЦАГ АГААРЫН ДЭЛГЭЭЖИЙН МЭДЭЭЛИЙГ 8 ДУГААР НУУРЭЭС УНШИНА УУ

8 658 000 029 112 0 08 39

Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

Иргэн таны орлого, зарлагыг тэнцүүлнэ

ҮГЭЭР ХИЙРХЭГЧДЭД ҮНЭН ТӨРХ БАЙДАГГҮЙ

НАЛАЙХ ДҮҮРГИЙГ ХОНКОНГ ШИГ БОЛГОНО

Оюутолгойн ашгийг монголчууд хүртэх ёстой

ХҮН ШИГ АМЬДРУУЛЖ, УЛС ШИГ ХӨГЖҮҮЛНЭ
 ТӨРӨӨ ХЯМРАЛААС ГАРГАЖ, ТҮМНЭЭ ЯДУУРЛААС АВАРНА
 АВЛИГАЧДЫГ ЦЭЭРЛҮҮЛНЭ

Улаанбаатарчууд Цэвэр, аюулгүй орчинд амьдарна

Улс төрийн томилгоог таслан зогсооно

2017 онд нийслэл метротой болно

ХК-ийн НОГДОЛ АШГААС ТӨЛЖ БАРАГДУУЛНА

Малчдад цалин олгоно

"ДАВХАР ДЭЭГ-ТЭЙ" ЗАСГИЙН ГАЗАР БАЙГУУЛАХҮЙ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АМАРГҮЙ ШАЛГУУРЫГ ХАНГАЖ, ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛД ХӨЛ ТАВИЛАА

Монгол хүн бүрийн өрийг цайруулна

Амьдралд хэрэгжих боломжгүй хоосон амлалт өгч, түүнийг төлөө хариуцлага хүлээдэггүй хүмүүсийг популистууд гэж нэрлэж болно. Тэд иргэдийг бодит байдлаас хөндийрүүлэн, үл биелэх хоосон итгэл найдлага, хийсвэр аз жаргал руу ямагт түлхдэг. ▶3

ЗГМ: СЭДЭВ

Дээд боловсролын доройтол ажилгүйдлийн шалтгаан болжээ

Ажлын байрны хамсдал боловсролын салбараас үүдэлтэй

Б.Баярмаа
 @bayarmaaZGM

Хөдөлмөрийн зах зээл ирэх жилүүдэд хүрээгээ тэлж, илүү олон боловсон хүчин шаардаж байна. Манай улсад энэ онд 76.4 мянган шинэ ажлын байр бий болох эерэг төлөв бий. Гэвч нөгөө талд их, дээд сургууль төгссөн залуус ажил олгогчдоос татгалзсан хариу

сонсож, ажилгүйчүүдийн эгнээнд шилжээр байгаагийн шалтгаан юу вэ. Өнгөрсөн онд 10 мянган ажлын байр сул байсан бол 118.8 мянган ажилгүй иргэн бүртгэгджээ. Энэ хавар олон мянган шинэ төгсөгч ажлын талбар дээр гарна. Гэвч тэд улсын эдийн засгийг чирэх ажиллах хүч болж чадах эсэх нь эргэлзээтэй. Учир нь манайд боловсон хүчин бэлдэж буй сургуулиуд, хөдөлмөрийн зах зээл хоорондын уялдаа маш сул байдаг.

2013 онд их, дээд сургууль төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт 75.6 хувьтай байсан бол 2016 онд 68.4 хувь болж буурсан.

▶5

FT FINANCIAL TIMES

Ам.долларын ханш суларсан 17 шалтгаан

Рожер Блиц

Он гарсаар ам.долларын индекс 2.5 хувь унаад байна. Гэхдээ шалтгааныг нь хүмүүс янз бүрээр тайлбарлах байх. Шалтгаан хангалттай бий. Энэ тухай шинжээчдээс илүү стратегич, хөрөнгө оруулагчид олон талтай, эсрэг тэсрэг байр суурь илэрхийлж байна. Тиймээс бид энэ талаар өөрсдөө дүгнэлт хийхээс илүүтэй тэдгээр байр суурь, тайлбарыг шууд хүргэсэн нь ач холбогдолтой гэж үзлээ.

1. Ам.долларын ханш суларч байгаа нь шинэ зүйл биш. Энэ

бол 2017 оны эхэн үеэс эхэлсэн үзэгдэл.

2. Ам.долларын ханш хэтэрхий өндөр байсан. Одоо харин зөв чигтээ явж байна.

3. Өөрчлөлтийн салхи сэвэлзэж байна. Ам.долларын бухын зах зээл долоон жилийн дараа баавгайн зах зээлээр солигдож байж мэдэх юм.

4. Ам.долларын ханш унаж байгаа нь сүржигнэхээр асуудал биш.

▶9

ЗГМ: ИНФОГРАФИК

ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН МАРГААН

маргааны төрөл (2017 онд)

2016	2017
1079	1060
121	145
269	216
39	12
105	60
60	38
223	270
97	14
71	96
3	0
20	20
99	92

Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүх ©

ЭДИЙН ЗАСАГ

Шинэ журам ломбардуудыг цэгцэлж чадсангүй

Г.Байгал
 @baigalZGM

Хөрөнгийн зах зээлийн түүхэнд анх удаа банк бус санхүүгийн байгууллага хувьцаагаа олон нийтэд арилжаалах гэж байна. Өнгөрсөн лхагва гарагт Монголын хөрөнгийн биржид IPO хийсэн "ЛэндМН" бол технологид суурилсан бизнес моделийг нь эс тооцвол жирийн л нэг ББСБ. Бичил санхүүгийн зах зээлд багтах энэ ББСБ тэр бүр компанийн давдаггүй Монголын хөрөнгийн биржийн амаргүй шалгуурыг хангаж, хөрөнгийн зах зээлд хөл тавилаа. Бас болоогүй, энэ зах зээлээс таван тэрбум төгрөг халааслахаар эзэж байна. "ЛэндМН"-ийн үнэт цаасны андеррайтар Mirae Asset Securities Mongolia компаниас мэдээлснээр хувьцааны захиалга идэвхтэй байгаагаас үзвэл Монголын хөрөнгийн зах зээлээс хүүссэн санхүүжилтээ ядах юмгүй татаж чадах нь.

Бичил хэмээн бидний нэрлэдэг санхүүгийн зах зээлийн жижиг тоглогчид сүүлийн жилүүдэд улам томорч, өсөн дэвжсээр. Гэтэл ББСБ-тай нэг ангилалд багтах зарим тоглогч өсөн өндийх нь бүү хэл системээрээ ялзарчихсан явна. Энэ зах зээлийн нэг гол тоглогч болох ломбардуудын үйл ажиллагаа хэрээс хэтрээд удлаа.

▶12

АЛТ 1323.39 1.2%	ЗЭС 7119 0.41%	10-ЧИНГИС БОНД 98.460 0.11%	ГЭРЭГЭ БОНД 100.16 0.06%	ХУРАЛДАЙ БОНД 113.64 0.13%	АМ.ДОЛЛАР 2398.22	ЮАНЬ 377.03	РУБЛЬ 42.24
-------------------------------	-----------------------------	--	---------------------------------------	---	-----------------------------	-----------------------	-----------------------

Улс төр

Авлигаас үүдэн 70 орчим тэрбум төгрөгийн хохирол учирчээ

Авлигын индексийн судалгааг 130 оронд зэрэг зарлалаа

Б.Сэлэнгэ
ЗГМ

Берлинд төвтэй олон улсын “Транспаренс Интернэшнл” байгууллагаас дэлхий даяар 2017 оны “Авлигын төсөөллийн индекс”-ийг зарласан. Авлигатай тэмцэх байдлыг илтгэсэн тус индекс Монгол Улс 103 дугаарт эрэмбэлэгдсэн байна. Энэ нь 2016 оныхоос 16 байраар ухарсан үзүүлэлт аж.

Олон улсын байгууллагууд тус индексийг гаргахдаа салбар бүрийг 0-100 оноогоор дүгнэдэг бөгөөд нийлбэр нь 50 онооноос доош бол авлига ноцтой хэмжээнд байгааг харуулж байгаа юм. Манай улсын оноо өнгөрсөн онохоос хоёроор буурч, 36 оноо авсан.

Авлига хамгийн багатай орноор Шинэ Зеланд, Дани нэрлэгдсэн бол хамгийн их орноор Өмнөд Судан, Сири, Сомали оржээ.

Монгол Улс өнгөрсөн жил мөн 15 байраар ухарч 87 дугаарт эрэмбэлэгдэж байсан юм. Үүнээс харвал Монгол Улс хоёр жилийн дотор 31 байраар ухарсан харамсалтай үзүүлэлт гарч байгаа юм.

“Транспаренс Интернэшнл Монголиа” байгууллагын гүйцэтгэх захирал О.Батбаяр “Авлигын индексийн судалгааг өнөөдөр дэлхийн 130 оронд зэрэг зарлаж байна. Авлигын индексийн Монгол дахь судалгааг улсын гэх гурван засаглал дахь



Монгол Улс хоёр жилийн дотор авлигын индексээр 31 байраар ухарч, 103 дугаарт бичигдээд байна.

С.Батсайхан / ЗГМ

авлигыг үндэслэн тооцсон.

Ерөнхий зөвлөмжийн дагуу хууль тогтоох, гүйцэтгэх байгууллага, шүүх засаглалууд авлигын эсрэг шаардлагатай эрх зүйн орчинг бүрдүүлэх, шүүгч, прокурорууд шударга шийдвэр гаргах, хараат бус байдлыг бэхжүүлэх мөн төрийн байгууллагууд авлигын орчинг бүрдүүлэхгүй байх, зохиомол хүнд суртал, авлигын эрдэлийг үүсгэхгүй байх, бизнесийн салбарт чөлөөт өрсөлдөөн бий болгож, худалдан авалт, төсвийн зарцуулалтыг хариуцлагатай, ил тод болгох шаардлага тулгарч байна” гэсэн юм. Сүүлийн таван жилийн үзүүлэлт зогсонги байдалд орсон нь авлигын эсрэг чиглэлд хууль эрх зүйн томоохон өөрчлөлт хийгээгүйгэй холбоотой гэж үзжээ.

Түүнчлэн Дэлхийн шударга ёсны төсөл, Улс орнуудын хуулийн засаглалын индекс хоёр оноогоор буурч, 36 оноо авсан нь хуулийн засаглал дахь шударга байдлын үнэлгээ буурсныг харуулж байгаа юм. Улстөрчдийн нөлөө ба авлигын эрдэл прокурор болон шүүгч нарын шийдвэрт нөлөөлж байгаа нь оноо буурах үзүүлэлт болдог гэж “Транспаренс Интернэшнл” байгууллагаас зөвлөлөө.

Мөн Төрийн байгууллагууд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд зохиомол бэрхшээл, саад тогтор учруулж, улмаар авлигын шалтгаан нөхцөлийг үүсгэж байгааг хэлсэн юм.

Авлигатай тэмцэх газрын 2017 оны тайланг харвал тус байгууллага хуульд заасан харьяаллын 1301 үйлдэлтэй,

654 холбогдогчтой, 427 эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулжээ.

Төрийн байгууллагууд бизнест зохимол бэрхшээл үүсгэдэг

Эдгээр хэргийг төрлөөр нь ангилбал эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэг 168 буюу 28.7 хувь, хахууль авах, хахууль өгөх гэмт хэрэг нийт 225 буюу

38.4 хувийг эзэлсэн байна. Энэ мэт гэмт хэргүүдийн улмаас учирсан хохирол өнгөрсөн онд 84 хувиар өсөж, 70 орчим тэрбум төгрөгт хүрчээ. Үүнээс хохирлын нөхөн төлөлт 3.4 тэрбум төгрөг болсон байна. Мөн эд хөрөнгө битүүмжлэх ажиллагаа 2.8 дахин өсөж, 29.3 тэрбум төгрөгөөр үнэлэгдэх 11 төрлийн эд хөрөнгө болон бэлэн мөнгийг битүүмжлэн хамгаалжээ. [ЗГМ]

Монгол Улсын авлигын ИНДЕКС:		
	ОНОО	БАЙР
2015 он	39	72
2016 он	38	87
2017 он	36	103

ТОВЧХОН

» ТОО

60

Тэрбум төгрөг. Нийгмийн даатгалын сангийн чөлөөт мөнгөн үлдэгдэлд өнөөдрийн байдлаар 660 тэрбум төгрөг байна. Тус мөнгийг арилжааны банкуудад хуваан, хүүтэй хадгалсан байдаг аж. Энэ онд тус хүүгийн орлогоос 60 тэрбум төгрөг олохоор төлөвлөжээ.

» ТОВ

Хүн ам, орон сууцны ээлжит тооллогыг 2020 онд зохион байгуулахаар болсон байна. Тооллогын дүнг мөн оны зургадугаар сард танилцуулах аж. Харин гадаадад байгаа иргэдээ онлайнгаар тоолох нөхцөлийг бүрдүүлэхээр ажиллаж байгаа юм.

Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын 21 дүгээр хуралдаан энэ сард Москва хотноо болно. Хуралдаанаар худалдаа, эдийн засаг, тээвэр, бус нутаг, эрчим хүч, байгаль орчин, хөдөө аж ахуйн салбарын хамтын ажиллагааны тулгамдсан асуудлыг хэлэлцэх аж.

ЭШЛЭЛ



МАХН-аас хөөнөө гэсэн ойлголт огт байхгүй. 1990 оноос ардчилал гарч, хэн нэгнийг намаас хөөдөг асуудал байхгүй болсон. Итгэл үнэмшлээрээ хүмүүс нэгдээд явж байгаа. Би МАХН-аас сайн дураараа гарч болно. Гэхдээ намын гишүүд нь намайг гарч болохгүй гээд байгаа юм. Тиймээс би хувь хүнийхээ хувьд ч, улс төрийн шийдвэр гаргасны хувьд ч хэн нэгнийг хөөлөө гэхэд явчихдаг хүн биш. Хувь хүнийхээ үзэл бодлоор МАХН-д би байх шаардлагагүй байж болно. Харин олон зуун гишүүний итгэл найдварыг хөсөрдүүлэх эрх надад байхгүй.

УИХ-ын гишүүн О.Баасанхүү

ТОДРУУЛГА & ЗАЛРУУЛГА

Уншигч та манай сонины мэдээ, нийтлэл, сурвалжилгатай холбоотой тодруулж, залруулах шаардлагатай санал, хүсэлт байвал

» **INFO@ZASAG.CO**

Утас: 99903584 хаягаар бидэнтэй холбогдоно уу.

ЗАСГИЙН ГАЗАР

“Саусгоби сэндс” өрөө бүрэн барагдуулжээ

“Саусгоби сэндс” компанийн гүйцэтгэх захирал Ч.Мөнхбат ЗГХЭГ-ын дэд дарга У.Бямба-сүрэнгэ уулзахдаа тус компани шүүхийн шийдвэрийн дагуу 35.3 тэрбум төгрөгийн өрөө бүрэн төлж барагдуулсныг хэллээ.

Засгийн газраас 2016 онд “Саусгоби сэндс” ХХК-ийн улсын төсөвт төлөх 35.3 тэрбум төгрөгийн талаар авах арга хэмжээний тухай тогтоол гаргасан юм. Энэ тогтоолд улсад төлөх дээрх мөнгөнөөс 15 тэрбум төгрөгийг 2016 болон 2017 онд тэнцүү хуваан төлөх, үлдэх 20,3 тэрбум төгрөгийг Тавантолгой уурхайд ажил гүйцэтгэх замаар төлж барагдуулах үүргийг



компанид өгсөн юм. Шүүхийн шийдвэр болоод Засгийн газрын тогтоолыг төвлөсөн хугацаанд нь бүрэн биелүүллээ гэж тус компанийн гүйцэтгэх захирал хэллээ. Тэрбээр “Компани дампуурлын ирмэгт тулсан хүнд хэцүү үед хувийн хэвшлээ дэмжих

шийдвэр гаргасан Засгийн газарт талархаж байна. Бид 400 гаруй ажилчдаа цалин, орлоготой нь авч үлдэж чадлаа” гэсэн юм.

Тус компани 2018 онд 5.5 сая тн нүүрс экспортод гаргах, 800 мянган тн-ыг нь баяжуулж гаргахаар төлөвлөжээ. [ЗГМ]

Нийслэлийн захиргааг Яармагт шилжүүлэхийг даалгав

НИТХ, Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын алба, түүний харьяа байгууллагуудыг Хан-Уул дүүргийн дөрөв, наймдугаар хорооны нутаг дэвсгэр /Яармаг шинэ төв/-д шилжүүлнэ. Тэгвэл энэхүү ажлын бэлтгэлийг шуурхай хангаж ажиллахыг Засгийн газраас нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид даалгав.

Энэ нь хотын төвийн хэт төвлөрөл, автомашины түгжрэл, агаарын бохирдлыг бууруулахаас гадна хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлж эхлэх, бизнесийн таатай орчин бүрдүүлэх, аялал жуулчлалын шинэ төв байгуулах, иргэдэд нутгийн

захиргааны үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилготой юм.

Нийслэлийн төр, захиргааны байгууллагуудад 1933 хүн ажилладаг. Өдөрт дунджаар 5700 иргэн, аж ахуйн нэгжид 332 нэр төрлийн үйлчилгээ үзүүлдэг байна. Яармагт шилжүүлнээр үйлчилгээ авах хэдэн мянган хүн хотын төвийг зорих шаардлагагүй болох юм.

Яармаг орчмыг худалдаа, эдийн засгийн төв болгон хөгжүүлэхэд томоохон түлхэц болно хэмээн үзэж байгаа аж. Өнгөрсөн хугацаанд Яармагт дэд бүтцийн бүтээн байгуулалт хангалттай хийснээс гадна хүн ам шигүү суурьшаагүй тул газар чөлөөлөх шаардлагагүй.

НЭЭЛТТЭЙ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТ

Огноо: 2018.02.23

Тендер шалгаруулалтын нэр: **АВТОМАШИНЫ БЕНЗИН КАРТ НӨХЦӨЛӨӨР НИЙЛҮҮЛЭХ** компанийг сонгон шалгаруулах тендер

Тендер шалгаруулалтын дугаар: МИАТ/201801004

МИАТ ХК нь эрх бүхий тендерт оролцогчдоос “АВТОМАШИНЫ БЕНЗИН КАРТ НӨХЦӨЛӨӨР НИЙЛҮҮЛЭХ” тухай хялбаршуулсан цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45 хоногийн** дотор хүчинтэй.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд: Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 3 жилийн дундаж борлуулалтын орлого 1,5 тэрбум төгрөгөөс багагүй байна.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **800 сая төгрөгөөс багагүй байна.** Санхүүгийн чадавхийг харуулах: **2015, 2016, 2017 оны жилийн эцсийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан, аудитийн дүгнэлтийн хамт.**

Сүүлийн 3 жилийн аль нэг хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй ажлын өртөг 800сая төгрөгөөс багагүй байх, мөн жагсаалтыг ирүүлэх.

Нефтийн бүтээгдэхүүн борлуулах тусгай зөвшөөрөлтэй байна.

Тендерийн хамт 16,000,000 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2018 оны 04-р сарын 05-ны өдрийн 11.00 цагаас** өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2018 оны 04-р сарын 05-ны өдрийн 11 цаг 30 минутанд** нээнэ.

Гадаадын хуулийн этгээд тендерт оролцох боломжгүй Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

ХАЯГ:
Хан-Уул дүүрэг, 10-р хороо
МИАТ ХК
Харилцах утас: 7004-9860, 91914093
Факс: 976-11-7004-9919
Өрөөний дугаар : Хангамж, үйлчилгээний хэлтсийн 103 тоот



УБТЗ нийгэмлэгийн төлсөн онцгой албан татварын асуудлыг УИХ шийднэ

УБТЗ хувь нийлүүлсэн нийгэмлэгээс 1998-2015 оны хооронд төлсөн дизелийн түлшний онцгой албан татвар болох 73.8 тэрбум төгрөгийг тухайн жилүүдийн улсын төсвөөс суутган тооцох талаар УИХ-д өргөн мэдүүлж

шийдвэрлүүлэхээр болов.

Японы Олон улсын хамтын ажиллагааны банкнаас төмөр замын тээврийг сэргээн сайжруулах зорилгоор МОНП-1, МОНП-2 хөнгөлөлттэй зээлүүдийг авсан. Мөн гэрээний дагуу

гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээс тооцсон алданги, зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрөөс дизелийн түлшний онцгой албан татварыг суутган тооцох асуудлыг УИХ-аар шийдвэрлүүлэхээр тогтлоо.

Дарханы ДЦС-ыг 11 сая еврогоор өргөтгөнө

Монгол Улсын Засгийн газар, ХБНГУ-ын Засгийн газартай хамтран Эрчим хүчний үр ашиг хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр болсон.

Энэ хүрээнд Дарханы дулааны цахилгаан станцын турбиныг 35 мкгв-аар өргөтгөхөөр болоод байв. Гэвч төслийн анхны ТЭЗҮ-д нийт төсөвт өртгийг багаар

тооцсон, тус станцын өөрийн хөрөнгөөр хийх байсан ажил хийгдээгүй зэрэг шалтгаанаас болж 11 сая еврогийн нэмэлт санхүүжилтийн шаардлага үүссэн байна.

Дээрх санхүүжилтийн 6.5 сая еврог Монголын тал, үлдсэнийг нь Германы нэн хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлэхээр

тогтсон. Гэхдээ Монголын талын гаргах санхүүжилтийн 1.5 сая евро буюу 3.4 тэрбум төгрөгийг 2017 оны төсөвт тусгасан. Харин үлдэгдэл таван сая еврог нь 30 жилийн хугацаатай, эхний таван жилд үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх жилийн хоёр хувийн хүүтэй зээлээр санхүүжүүлэхээр тохиролцжээ. [ЗГМ]

Нийтлэлчийн булан

Үгээр хийрхэгчдэд үнэн төрх байдаггүй

Улстөрчдийн популизм эцэстээ улс төрийн институцид нэвт шингэжээ

Б.Даваатогтох
@datoZGM

Хямралын үед ард түмний сэтгэл зүй хүчтэй удирдагчийг хүсэмжлэх хандлагатай болдог үүдэн популистууд хүчээ авдаг нь манай улс төрийн амьдралаас тод харагддаг. Ийм үед популистууд онол, судалгааг үл тоомсорлож, олны сэтгэлийг хөөргөж, тэдний сэтгэл хөдлөлд тулгуурлан, этгээд зан үйл, элдэв хоосон үгээр нэр хүнд олж авдаг. Товчхондоо, амьдралд хэрэгжих боломжгүй хоосон амлалт өгч, түүнийгээ төлөө хариуцлага хүлээдэггүй хүмүүсийг популистууд гэж нэрлэж болно.

Тухайн улс орон улс төр, эдийн засгийн хямралтай, ард иргэдийн амьдрал ядуу тарчиг байхад олон нийтийн сэтгэл зүй хэвшмэл бус өвөрмөц нэгэн удирдагчийг хүсэмжилдэг нь популистуудын амжилтад хүрэх гишгүүр болдог байна. Популист улстөрчид хямралаас гарах хамгийн хялбар арга замыг амлан, жирийн хүмүүсийн чихний чимэг болсон баялгийг тэгш хуваарилах, албан тушаалтны эрх ямбыг хасах, нийгэмд шударга ёс тогтоох зэрэг уриа лоозон дэвшүүлдэг.

Энэ төрлийн популист улстөрчид үе үеийн парламентад байсан, байна, хойшид ч байх биз. Тэд өнөөгийн, бас ойрын ирээдүйн жижиг ашиг сонирхлынхоо төлөө олон нийтэд таалагдах чихэнд чимэгтэй зүйлүүдийг ярьж, зогсоох, болиулах, хаах, өөрчлөх, огцруулах, жагсах, тэмцэх гэсэн хамгийн хялбар “шийдэл”-ийг дэвшүүлж, улс төрийн оноо

цуглуулан, магадгүй дараагийн сонгуулийн бэлтгэлээ хангаж суугаа.

Өөрсдийгөө жинхэнэ удирдагч, эх орон ард түмнийгээ төлөө чин сэтгэлээр тэмцэгч мэтээр харуулахын тулд үг, үйлдэл бүр нь төр засаг, хэн нэгэн, аль эсвэл хэсэг бүлэг рүү чиглэж, шүүмжлэхийн дон туссан хүмүүс улс орныг доош нь чангаахаас, өөд татаж байсан түүх үгүй. Тэд олон түмэнд зулгуудаж, зөвхөн сонсохыг хүссэн тэр зүйлийг л ярьдаг нь нууц биш. Олон түмний сэтгэл зүй тогтворгүй тул түүнд тохируулан популист улстөрч ухамсар, зорилгогүйгээр нэгээс нөгөөд үсчих нь харагддаг.

Жишээ дурдахад, 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн өмнө “Сант Марал” судалгааны төвөөс хийсэн судалгаагаар хамгийн рейтинг өндөртэй улстөрчөөр МАХН-ын дарга Н.Энхбаяр тодорч байв. Үүний араас УИХ-ын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Ц.Нямдорж, С.Жавхлан, С.Ганбаатар нар эрэмбэлэгдэж, топ таван улстөрчөөр шалгарсан билээ. Хамгийн сонирхолтой нь нийслэлчүүд УИХ-ын гишүүн С.Жавхланг хамгийн нэр хүндтэй улстөрчөөр тодруулсан явдал байлаа. Уул уурхайн томоохон төслүүдийн үр ашиг нь ард түмэнд ирэхгүй байгааг шүүмжилдэг учраас тэд дээрх рейтингийг тэргүүлсэн байсан.

Хийсэн бүтээсэн байтугай юу хийж бүтээх нь тодорхойгүй байдаг популист улстөрчдийн балаг эдийн засгийг сөхрүүлж, улс орныг үймээн самуунд уруу татах хүртэл хор хөнөөлтэй болохыг улс төр судлаачид онцолдог. Гэхдээ популист улстөрчдийн жагсаалт дээр дурдсанаар дуусахгүй. Учир нь манай улстөрчид “Чи популист, би популист биш” гэж маргах хэрэггүй юм. Бүгдээрээ адилхан популист учраас хоорондоо ингэж маргалдах хэрэг байхгүй. Үүний оронд бүгдээрээ популизмд нэвт автсанаа хүлээн зөвшөөрөөд, гарах арга замаа

хайх хэрэгтэй болов уу.

Улстөрчдийн популизм эцэстээ улс төрийн институцид нэвт шингэсэн. Үүнийг улс төрийн намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдсан амлалтуудаас харж болно. Ард түмний саналыг авахын тулд “Эрдэнэс Тавантолгой” компанийн 1072 хувьцааг амь оруулж, ногдол ашиг тараах замаар монголчуудын 5.8 их наяд төгрөгийн өрийг төлнө хэмээн амласан улс төрийн хүчин бий.

Цалин тэтгэвэр, тэтгэмжийг нэмэх, халамжийг хавтгайруулах бодлого жилийн жилд аль ч намын сонгуулийн мөрийн хөтөлбөрт багтсаар ирсэн. Мэдээж, амлалтынхаа дагуу өнгөрсөн хугацаанд цалин, тэтгэвэр, тэтгэмжүүд нэмэгдсээр ирлээ.

● **Амьдралд хэрэгжих боломжгүй хоосон амлалт өгч, түүнийгээ төлөө хариуцлага хүлээдэггүй хүмүүсийг популистууд гэж нэрлэж болно.**

● **Популизм улстөрчдийн давын өмнө барьж авдаг сонгомол арга мэхнээс үүдсэн өвчин юм.**

● **Ард иргэдийг бодит байдлаас хөндийрүүлэн, үл биелэх хоосон итгэл найдлага, аз жаргал руу ямагт түлхдэг.**

Эдийн засгийн өсөлт, инфляцын дүнтэй уялдуулж, цалин, тэтгэврийг нэмэгдүүлэх нь



С.Батсайхан / ЗГМ©

Цагийн жамаар популистуудын ярьдаг сэдвүүд цөөрч, хууртагддаг хүмүүс нь багасах байх. Учир нь популизм тооцоо, судалгаанд дээр суурилдаггүй.

байж болох ч үүнтэй зэрэгцээд халамжийг хавтгайруулах бодлого хүчтэй хэрэгжсээр л байна. Хүүхдийн мөнгө, одонтой ээжүүдийн мөнгө, оюутны тэтгэлэг зэрэг халамжийн бодлогуудыг цэгцлэх талаар оролдлого хийдэг ч бүтэлгүйтсэн.

Энэ бүхэнд цэг тавих боломж нь улстөрчид болон улс төрийн хүчнүүд популизмаас татгалзах. Ингэж байж төрийн бодлого жанжин шугамаа олж, улс орны хөгжлийн хөрс суурь нь бүрдэнэ.

Нэг талаар, үндэсний эрх ашгаа хувийн болон нам, эвсэл, бүлгээс дээгүүр тавих сэтгэл, улс орныг удирдах мэдлэг боловсрол, зөвшилцөлд хүрэх, буулт хийх үр чадвар манай улстөрчдөд

дутагдсаар байна. Популизмаас болж ямар ч тооцоололгүй, эдийн засгийн үндэслэлгүй, улс орноо бус, амин хувина бодсон шийдвэр гарах нь цөөнгүй. Тухайлбал, одоогийн эрх баригчид 2016 онд татвар нэмэхгүй гэх популист амлалт өгч, УИХ-ын сонгуульд ялалт байгуулсан. Гэтэл тэр нь биелэх боломжгүй мэдээд ОУВС-гийн нэрийг урдаа барьж хэсэг үзэв. Эцэстээ үнэнд гүйцэгдэж, ОУВС-гийн нэрийг барьсан нь илчлэгдэв. Монголын зарим улстөрч нийгэмд популизмын үр суулгаж, түүнийгээ усалсаар цөөнгүй жилийн ардаа орхисон. Үр дүнд нь Монгол Улс хөрөнгө оруулалт татахад хүндрэлтэй болж, рейтинг нь улам уруудан,

харин зээл, санхүүжилт, хөрөнгө оруулалт татах өртөг нь улам өссөөр байна.

Гэхдээ энэ бүхэн сүүлийн хэдэн жилийн дотор бий болчихсон асуудал биш, олон жилийн турш хуримтлагдсан, нөгөө талаас Монголын улстөрчдийн давын өмнө барьж авдаг сонгомол арга мэхнээс үүдсэн өвчин юм. Энэхүү өвчлөлөөс салахын тулд бодлого зөв тодорхойлохоос гадна Монголын улстөрчид овлигогүй ааш араншингаа дарах ёстой болж байна. Хэдийгээр эрх чөлөөт, ардчилсан нийгэмд хүн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж, жагсах, шаардах эрх нь нээлттэй ч популист улстөрчилтөөр санасандаа хүрэх оролдлого нь хэрээс хэтэрлээ. Улсынх нь данс улайчихсан байхад цалин, тэтгэвэр нэм хэмээн жагсаал цуглаанаар сүрдүүлж, гадаадын хөрөнгө оруулагчдад төр нь тогтворгүй бодлоготой гэдгийг байнга сануулах нь хэр зохимжтой вэ.

Асуудал байгаа бол шийдэх нь зөв. Гэхдээ популизм хийхгүйгээр УИХ, Засгийн газрын түвшиндээ шийдвэрлээд явах гарц байгаа гэдгийг улстөрчид хэнээр ч хэлүүлэхгүй мэдэж л байгаа. Популистууд ардчилсан шаардлагыг дэвшүүлж буй мэт харагдах ч эдийн засгийн бэрхшээлийг тайлбарлах нь өнгөцхөн шинжтэй байдаг. Популистуудыг ерөнхийд нь эгэл хялбар шийдвэрт эрмэлзэгчид гэж нэрлэж болно. Гэвч тэдний хялбар шийдвэр төрийн бодлого, үндэсний эрх ашигтай зөрчилдөх учир бодит ажил болж биелэх нь ховор. Ард иргэдийг бодит байдлаас хөндийрүүлэн, үл биелэх хоосон итгэл найдлага, аз жаргал руу ямагт түлхдэг байна.

Цагийн жамаар популистуудын ярьдаг сэдвүүд цөөрч, хууртагддаг хүмүүс нь багасах байх. Учир нь популизм тооцоо, судалгаанд дээр суурилдаггүй. Дутуу дулимаг мэдлэг, мэдээлэл, хоосон лоозон, заримдаа эх оронч сэтгэлийн хамгийн энгийн, хялбарчилсан хувилбар болох ард түмэндээ хайргайгаа харуулах ганц сонголт дээр тоглож хийдэг. Ийм “эх орончид” бидэнд хэрэггүй. Тиймээс энэхүү цөөн дүртэй, ганц үзэгдэлт жүжгээс салах нь Монголын улс төр эрүүл байх, улс орон нь хөгжил рүү зөв замаар тэмүүлэх нэг гарц мөн билээ. [ЗГМ]

С.ЦОГТБАЯР ЗУРЖ БАЙНА



Судлаачийн үг

Геополитикийн толины тусгал-АНУ



АНУ амжилт олох тусам байр суурь нь суларч ирсэн гэх нь бас л этгээд дүгнэлт

Олхонуд Баярхүү
Судлаач профессор

Эммануэл Валлерштайн гэж миний сонирхон уншдаг америк профессор бий. Тэрбээр дэлхийн түүх, түүний хэтийн төлөв, тэр дундаа АНУ-ын нэн шинэ түүхээр бичдэг, судалдаг. Үүндээ системийн анализ хийдэг. Түүний бичсэнээс сэдэвлээд АНУ-ын түүхэн геополитикийг хөндөхөөр шийдлээ.

Дэлхийн II дайны дараа дэлхийн геополитик гурван үе шат дамжсан, тэр тоолонд нь АНУ уруудах зам руугаа орсон хэмээн ноён Валлерштайн үздэг нь үнэн ч юм шиг, эсвэл этгээд байр суурь гэлтэй.

Үүнд:

- 1945-1970 он: АНУ маргашгүй давуу байдалтай байжээ
- 1970-2001 он: АНУ аажмаар суларч ирсэн гэх нь бас л этгээд дүгнэлт. СССР нурсан явдал АНУ-ын ялалт бус, харин
- 2001 оноос хуучин эрх мэдлээ хэргээр ганц талын тоглолт хийсэн ч уналтыг нь улам гүнзгийрүүлсэн.

АНУ амжилт олох тусам тэргүүлэх байр суурь нь аажмаар суларч ирсэн гэх нь бас л этгээд дүгнэлт. СССР нурсан явдал АНУ-ын ялалт бус, харин



ВВМ©

эхний томхон бэрхшээл байсан аж. Гэнэгүй, бэлтгэлгүй байж байтал Горбачев өөрөө “Хүйтэн дайн”-ы ханыг нураагаад өгсөн, АНУ юу хийхээ мэдээгүй. Өрнөд Европ нь СССР-ийн эсрэг АНУ-тай хамтран нэг фронт болж байсан нь суларсан, Америкийн үг нөлөөгөөр европчууд явахад больсон, гуравдагч ертөнцөд СССР-ийн үүргийг хумихын төлөө тэмцэж байсан нь алга болсон. Тэр хэрээрээ хөгжиж буй ертөнцөөс АНУ холдсон. Араб, Иран, Афганы эсрэг АНУ үр дүнгүй сөрөн зогсож байна.

Олон улсын эрх зүйн хэмжүүрээр бол АНУ нь Араб дахинд түрэмгийлэгч гэж харагддаг болсон. СССР нь хөгжиж буй орнуудад нийгмийн байгууллага тулган хүлээлгэх гэж хэрхэн ажиллаж байсан, яг түүнийг АНУ давтсан. Араб дахин, лалын ертөнцөд АНУ цэрэглэн халдахад тэр ажиллагааны 90 хувийг АНУ санхүүжүүлдэг, Америкийн эрх ашигт үйлчилсэн үр дүн байхгүй.

Өөр бусад улс түүн шиг үүрэг гүйцэтгэж чадахгүй байна. Гэлээ гээд үнэмлэхүй давуу үүрэгтэй гэсэн үг биш. Хэт их гүрэн, ганц туйл гэх хэллэг үе өнгөрөөлөө, хүчний шинэ төвүүд үүслээ хэмээн тэрбээр үздэг.

Америкт хэт их ачаа үүрүүлж, тэр хэрээрээ хэт их хариуцлага нэхүүлэхгүй байхыг Америкийн эрдэмтэд энэ мэтээр илэрхийлж, Ерөнхийлөгч Трамп ч тэдний үзэл бодлоос хуваалцаж буй. АНУ-ын хүчирхэгжлийн тухай 10-15 жилийн тэртээ юу гэж ярьж онолдож байсан нь сонин түүх юм.

Обамагийн өмнөх Ж.Буш энэ талаар ам шүд алддаг, тэр хэрээрээ АНУ-ын дэлхий дахины үүрэг хариуцлагыг илтэд тунагладаг байсан баримтаас эргэж сөхье. Тэрбээр эрх барьсан нэг жилийнхээ тайланг улс орондоо хандсан илгээлт хэлбэрээр 2002 оны эхээр АНУ-ын Конгресс, Сенатын хамтарсан хуралд тавихдаа “Муу муухай юмны тэнхлэг” (Axis of Evil) буюу төгтөрийн тэнхлэг, хор хөнөөлийн уурхай) гэсэн хачин нэр томъёо гаргаж ирсэн бөгөөд үүндээ Хойд Солонгос, Ирак, Иран зэрэг улсыг нэр зааж зүхсэн. “Ось зла” хэмээн оросуудын хөрвүүлсэн тэр нэр томъёо уг нь цоо шинэ юм биш байв. 1983 онд Өмнөд Солонгосын иргэний агаарын тээврийн нисэх онгоцыг Зөвлөлтийнхөн Сахалины агаарт устгаж сөнөөсний дараа АНУ-ын Ерөнхийлөгч Р.Рейган “Империал зла” буюу “Муу муухай юмаар дүүрсэн эзэнт гүрэн” хэмээн СССР-ийг нэрлэн зүхэж, марксизм-ленинизмыг түүхийн үнс нурам болгоно хэмээн андгайлж асан нь түүх болж үлджээ. Рейган хэлсэндээ яг хүрсэн, харин бага Буш, Обама нар тэгж чадаагүй, Трамп бүр ч чадахгүй.

Гэхдээ АНУ цор ганцаараа жанжлаад буй биш, түүнд найдвартай холбоотнууд бий. Тэднийгээ нийлүүлээд ертөнцийг мондиализм ба глобалчлал (даяаршил) гэх үзэгдлээр хөдөлгөж байгаа нь худлаа биш ээ. Франц хэлний “Le Monde” гэх үг, монголчилбол дэлхий. Эндээс мондиализм буюу махчилбал дэлхийчлэл гэсэн нэр томъёо гарчээ. СССР тэргүүтэй дэлхийн коммунист лагертай олон жил геополитикийн дуэль хийсэн Өрнийнхөн энэ тулаандаа эгнэгт ялж, эдүгээ дэлхий дээр геополитикийн цоо шинэ загвар тогтоон хэвшүүлэхийг зорихдоо мондиализмыг “нео” гэсэн тодотголтой хэрэглэж байна.

Үзэл суртлаар харш хоёр лагерийг хооронд нь залгаж ижилсүүлэн, нэгийг нь нөгөөд нь уусгах зорилгоор баруунд 1960-аад онд конвергенц, гүүр тавих, эдийн засгийн өсөлтийн үе шатны онол, нэгдмэл аж үйлдвэржсэн нийгэм, хувьслын

онол, үзэл сурталгүй болгох, нээлттэй марксизм зэрэг урсгалуудыг гаргаж ирэн геополитик, геозүл суртал, геоздрийн засгийн зэвсэг болгосон. Энэ нь цааш хөгжсөөр “дэлхийн нэгдмэл засгийн газар” бий болгох дээрээ хүрч, хэрэв хоёр систем дайсагналаа зогсоож нэг нь нөгөөдөө уусвал түүх өндөрлөнө хэмээсэн онолд (Ф.Фукуяама – “Түүхийн төгсгөл” өгүүлэл) хүргэжээ.

Социализмыг бодвол Америкийн капитализм нь өсөлтийн өндөр дээд үе шат мөн, энэ нь хөгжлийн туйлын, нэн сайн загвар бөгөөд нийтийн хэрэглээний өндөр дээд үе мөн. Капиталист социалист нийгэм-эдийн засгийн хоёр байгуулал нь нэг шинжтэй, орчин үеийн соёл аж үйлдвэр нийлүүлэг үндэстэй, дэлхийн улс орнууд зөвхөн аж үйлдвэржсэн буюу хөгжингүй, хоцрогдсон буюу буурай гэж ялгагдана, дэлхий ертөнц шинэ эрин үе болох нэлэнхүйдээ аж үйлдвэржсэн эрин үедээ дэвшин орж байна. Дорнод ба Өрнөд түүн рүү замнаж байна. Аж үйлдвэржсэн нийгэм бол салшгүй нэгдмэл ертөнц мөн. Аж үйлдвэржилт, ШУТ-ийн хувьсгал нь бүх улс орон, нийгмийн байгууллуудыг хил хязгааргүй болгож хар аяндаа цомхотгон нэгтгэхэд хүргэнэ. Бодитойгоор үйлчилж буй эдийн засгийн хоёр систем ялгаатайгаасаа төсөөтэй нь улам их болж байна. Аливаа үзэл суртал нь аж үйлдвэржсэн нийгэмтэй огт нийцшгүй гэх мэт үг өгүүлбэр 1960-1970-аад оны барууны олон арван

ном бүтээлээс (З.Безински, Г.Киссинжер, Ж.Болл, У.Ростоу, Р.Арон, Ф.Перру, Р.Энжелл, У.Бакингам, Ж.Адамс, П.Сорокин, Д.Рокфеллер, С.Липсет, Ж.Гэлбриет, Р.Гароди, Ж.Сартр гэх мэт хэдэн зуун эрдэмтэн, улстөрч) эшлэж болно.

Энэ дотроос бидний сайн мэдэх, коммунизмын адтай “дайсан” З.Безински гандан бууруулж ихийг туурвисан ба ОХУ-ын задрал, ирээдүйн их Хятадын геополитикийг 20 жилийн цаадах наадахтай нь номлосоор. “Зөвлөлтийн эвсэл: Нэгдэл ба мөргөлдөөн”, “АНУ, СССР-ийн улс төрийн систем: Конвергенц буюу хувьсал”, “Их сүйрэл XX зуунд буюу коммунизм мэндэлж мөхсөн нь”, “Дэлхийн системийн хямрал”, “Тоглолтын төлөвлөгөө: АНУ, СССР-ийн хоорондын тэмцлийн геостратегийн бүтэц”, “Шатрын их хөлөг” гэхчлэн олон арван ном зохиолд дээрхтэй адил төстэйгээр үл барам яг тэгж зөгнөсөн дүгнэлтүүд байх бөгөөд хүйтэн дайны төгсгөлөөр барууны судлаачдын таамаг хөдлөшгүй нь нотлогджээ.

Нэгэнтээ олон улсын харилцааны хоёр туйлт дэлхийн систем алга болж, PAX AMERICANA (Пакс-Американа) гэх ганц туйлт дэлхийд (энэ нь Америкийн энх тайван гэсэн утга бүхий латин нэр томъёо, хүчээр энх амгаланг тогтоогоод өөрийн хуулиар олон улсын харилцааг зохицуулна) оршин үлдсэн, үүнд тохирсон олон улсын харилцааны шинэ загвар, геополитикийн шинэ

номлол хэрэгтэй, энэ хэрэгцээг 1990-ээд онд “Неомондиализм”, “Дэлхийн шинэ дэг журам”, “Глобалчлал”, “Неоатлантисизм” зэрэг номлолоор орлуулжээ. Эдгээр нь угтаа нэг цогц номлол юм. 1991 онд Персийн буланд Иракийг цээрлүүлсний дараа АНУ-ын тэр үеийн Ерөнхийлөгч Ж.Буш анхлан дэлхийн шинэ дэг журмыг зарлаж, түүнээс хойш Б.Клинтоны үед хэвшүүлсэн, хүү Ж.Буш нь олон улсын терроризмын эсрэг эвслийн хэлбэрээр цааш нь шат ахиулсан, Обама Арабын ертөнц рүү салбарлуулсан, Трамп тэр эргүүлгээр буцаж гарч чадахгүй байна.

Аль 40-50 жилийн тэртээ барууныхны мөрөөдөж асан тэр шинэ орон, шинэ орон зай XXI зуун гараад нэгэнт бий болчихлоо. Энэ нь дэлхий даяараа бүс нутагчлан интеграцчилагдаж эхэлсэн, маш олон улс үндэстэн, соёл, иргэншлүүд “Нэгдмэл нэг дэлхий” рүү хандаж буй, АНУ ба түүний баруун дахь холбоотнууд мондиализм, глобалчлалын гол штаб нь, НҮБ-ыг чухам тэдний үзэмжээр залж чиглүүлдэг болсон, дэлхийн санхүү-аж ахуйн бүх тогтолцоо механизм-ОУВС, Дэлхийн банк, ДХБ, Давосын эдийн засгийн форум гэхчлэн чухал зангилаа зөвхөн барууныхны гарт үүгээр дамжин дэлхийн эдийн засгийн 77 хувийг тэд хянаж буй зэрэг олон үзүүлэлтээр нотлогдож байна л даа.

АНУ ба түүний холбоотнуудын мэдлийн бүс нутагт Европ, Ази-Номхон далайн зарим хэсэг, Латин Америк, Ойрх Дорнод, Африк бараг тэр чигтээ багтах ба АНУ-ын түүхэн өрсөлдөгч байж ирсэн СССР-ийн хууль ёсны залгамжлагч - ОХУ нь олон үзүүлэлтээр АНУ-д бараагүй хол хаягдаж, харин ч барууныхны зээлийн өртөн, барьцааны орон болжээ.

НҮБ-ын төсвийг хэдэн жилийн өмнө хэрхэн бүрдүүлж байснаар нь авч үзье. Дэлхийн хамтын нийгэмлэгийн гишүүн орны тоо 190 гаруй гээд бодоход АНУ төсвийнх нь 25 хувь, Япон 20.6, Герман 9.9, Франц 6.5, Итали 5.4, Британи 5.1, Канад 2.7, ОХУ 1.1, Хятад 1 хувийг тус тус бүрдүүлж байсан ба үлдэх 180 гаруй улс 22.2 хувийг нь хуваан төлж байв. Өөрөөр хэлбэл, нэр бүхий есөн улсад төсвийн 77.3 хувь ногдож байжээ. Энэ тоон дүнд эдүгээ зарчмын нэг их өөрчлөлт гараагүй болов уу.

Улс төрийн талаасаа бол АНУ “хүмүүнлэг энэрэнгүй”, “ардчилсан” үнэт зүйлсээрээ гул барин, дэлхий дахиныг ардчиллахыг шаардаж, энэ хэмжүүрээр дэлхийн улс орнуудыг дөрвөн хэсэгт ангилан харьцах болсон нь глобалчлалын шинэхэн онцлог, онцгойрол нь юм.

Үргэлжлэл бий.

[ЗГМ СОНИН]

“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургалч үзлийг илэрхийлж мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилгоо болгоно.

Түүш-ийн дарга
Эрдэнэбаатарын ДОЛГИОН
Утас: 99903574

Ерөнхий эрхлэгч
Баатарын ДУЛАМХОРЛОО
Утас: 99901637

Зөвлөх
Шатарбатын ДАВААДОЖ
Утас: 99901532

Орлогч эрхлэгч
Лхагважавын СУГАРМАА
Утас: 99903584

РЕДАКЦ
Улс төр, нийгэм, эрэн сурвалжаах мэдээллийн алба
Эдитор Б.ДАВААТОГХ
Утас: 99901637

Эдийн засаг, уул уурхайн мэдээллийн алба
Эдитор Б.Баяртөгтох
Утас: 99901532

Цахим контент, бүтээл үйлдвэрлэлийн алба
Эдитор Г.Баярсайхан
Утас: 99903574

ЗАР СУРТАЛЧИЛГАА
Утас: 99903581
99903578
99909472
99907843

ХАЯГ
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
I хороо, Энхтайваны өргөн чөлөө,
“Блю Скай тауэр” 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар, 1024
Утас: 70103131,
Факс: 7010606

ЦАХИМ ХУВИЛБАР
ubinfo.mn
Дугаарын удирдагч
Г.Баярсайхан



ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2018.02.23

Тендер шалгаруулалтын нэр: **АГААРЫН ХӨЛГИЙН МОДЕЛЬ НИЙЛҮҮЛЭХ компанийг сонгон шалгаруулах тендер**
Тендер шалгаруулалтын дугаар: **МИАТ/201801063**


МИАТ ХК нь эрх бүхий тендэрт оролцогчдоос **АГААРЫН ХӨЛГИЙН МОДЕЛЬ НИЙЛҮҮЛЭХ** тухай хялбаршуулсан цахим тендер ирүүлэхийг урьж байна. **/www.tender.gov.mn/**
Тендерийг **2018** оны **03**-р сарын **26**-ны өдрийн **09:00** төгрөгийг тушааж тендэрт оролцоно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш **45** хоногийн дотор хүчинтэй.
Тендэрт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд: Санхүүгийн чадавхийг харуулах 2015, 2016 оны жилийн эцсийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан, аудитийн дүгнэлтийн хамт ирүүлнэ.
Сүүлийн 3 жилийн аль нэг жилд гүйцэтгэсэн ижил төстэй гэрээний талаарх мэдээлэл, нотлох баримтын хамт ирүүлнэ.
Ирүүлж буй үнийн саналын 2 хувьтай тэнцэх тендерийн баталгаа ирүүлнэ.
Сүүлийн 3 жилийн аль нэг жилд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ нь: **165,907,000** төгрөгөөс багагүй байна. /Төсөвт өртгийн 70%/
Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **165,907,000** төгрөгөөс багагүй байна. /Төсөвт өртгийн 70%/
Тендерийг **2018** оны **03**-р сарын **26**-ны өдрийн **09:00** цагаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендэрт оролцогчдыг байлцуулан тендерийг **2018** оны **03**-р сарын **26**-ны өдрийн **09** цаг **30 минутанд** нээнэ.
Гадаадын хуулийн этгээд тендэрт оролцох боломжтой.
Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

ХАЯГ: Хан-Уул дүүрэг, 10-р хороо, МИАТ ХК
Харилцах утас: 7004-9860, 9904-5326, Факс: 976-11-7004-9919
Өрөөний дугаар: Хангамж, үйлчилгээний хэлтсийн 103 тоот

ЗГМ: Сэдэв

Эрэлтгүй салбарт мэргэжилтэн бэлтгэж буй нь их, дээд сургуулиудын алдаа

▲1 Ажил хийж буй төгсөгчдийн 30.4 хувь нь эзэмшсэн мэргэжлийнхээ үр ашгийг мэдэрч чадалгүй өөр салбарт зүтгэж байна. Харин 10 орчим хувь нь боловсролынхоо түвшнээ доогуур ур чадвар шаарддаг худалдагч, зөөгч, бармен, үйлчлэгч зэрэг ажил хийж буйг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн 4000 гаруй төгсөгчийн дунд хийсэн судалгаанаас харж болно. Ажилгүй байгаа төгсөгчдийн 54.1 хувь нь ажил хайгаад олдохгүй, 25.5 хувь нь мэргэжилд нь тохирох ажил олдохгүй байгааг дурджээ. Мөн 5.3 хувь нь цалин бага, 4.9 хувь ажил олгогчийн тавьсан



ХӨДӨЛМӨРИЙН ЯАРМАГ

Б.Ганбаяр / ЗГМ

Дээд боловсролын доройтол ажилгүйдлийн шалтгаан болжээ

ТӨГСӨГЧИЙН АЖИЛГҮЙДЭЛ


(Ажилгүй төгсөгчид мэргэжлийн чиглэл, сургуулийн төрлөөр)

МБСБ ТӨГСӨГЧИД



Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт ©

Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт, сургуулийн төрөл (хувиар)



шаардлагад нийцэхгүй байгаа учраас хөдөлмөр эрхлээгүй гэсэн хариулт өгсөн байна. Үүнээс үзвэл дээд боловсролын гэрчилгээтэй боллоо ч ажилтай, орлоготой болох баталгаа Монголд алга.

Их, дээд сургуулиуд хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг мэдэрч чадахгүй байгааг илтгэх нэг жишээг дурдъя. Сүүлийн үед моданд ороод буй бизнесийн удирдлагын мэргэжлийг дээд боловсрол эзэмшигчдийн гуравны нэг нь сонгож байна. Гэвч ийм мэргэжилтэй залуус ажилгүйчүүдийн эгнээнд олноороо шилжиж, нийгмийн хамгийн сул дорой давхаргыг улам зузааруулж байгаа нь харамсалтай. 2016 онд их, дээд сургууль төгссөн ажилгүй залуусын 16 хувийг дээрх мэргэжилтнүүд эзэлжээ. “Бизнес удирдлагын мэргэжил эрэлтгүй байх үед ийм чиглэлийн хувийн их, дээд сургуулиуд байгуулагдсан. Зах зээл нь ханаж, эрэлт буурсан ч сургуулиуд энэ мэргэжлээр урьдын адил элсэлт авсаар байгаа. Эдгээр сургуулиуд сургалтын хөтөлбөрөө эргэж харах цаг болсон” гэж “Мандах бүртгэл” дээд сургуулийн захирал Г.Нанжид хэлэв. Нэг хэсэг монголчууд хуульч, эдийн засагч, олон улсын харилцаа гэсэн мэргэжлийг

● **Ажилгүй байгаа төгсөгчдийн 54.1 хувь нь ажил хайгаад олдохгүй, 25.5 хувь нь мэргэжилд нь тохирох ажил олдохгүй байгааг дурджээ.**

● **Бизнесийн удирдлагын мэргэжлийг дээд боловсрол эзэмшигчдийн гуравны нэг нь сонгож байна.**

● **Өнгөрсөн онд ажилгүйдлийн түвшин 9.5 хувьтай байсан бол 2018, 2019 онд 10.1 хувь хүрч нэмэгдэх төлөвтэй.**

түлхүү сонгож байсан. Харин сүүлийн жилүүдэд бизнесийн удирдлагад хошуурч, хэтэрхий туйлшрах болсны гор нь ийнхүү хөдөлмөрийн зах зээл дээр илэрчээ. Мөнгө олж байвал бэлтгэсэн хүний нөөц нь шаардлага хангаж байгааг, төгсөгчид нь ажилд орж амьдралаа залуулж чадаж буй эсэхэд анхаардаг их, дээд сургууль дэндүү олон болжээ.

Дөрвөн жил зарцуулж сурсан ч тогтмол орлоготой болох магадлал хамгийн бага мэргэжлүүдэд бизнес удирдлагаас гадна багш, боловсрол судлал (20.4 хувь), үйлдвэрлэлийн технологи (10.3 хувь), инженер (8.1 хувь) зэрэг багтаж байгаа юм. Түүнчлэн нийгмийн халамж, биеийн тамирын чиглэлээр төгсөгчдөд боломж тун бага байгааг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын судалгааны секторын эрхлэгч И.Энхбаатар хэлсэн юм. Тэрбээр “Хөдөлмөрийн зах зээлийн шингээлт байхгүй болсон салбарт мэргэжилтэн бэлтгэж, нийлүүлсээр байгаа нь их, дээд сургуулиудын алдаа. 2017 оны судалгаагаар их, дээд сургууль төгсөгчдийн 68.4 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаа бол 22.2 хувь нь ажилгүй, 19.3 хувь нь эдийн засгийн идэвхгүй гэсэн дүн гарсан” гэлээ.

Шинэ төгсөгчдөд тулгардаг хамгийн том бэрхшээл нь ажлын туршлага. Сургуульд практик дадлага бага хийдэг, ажлынхаа ур чадварыг бүрэн эзэмшиж чадаагүйгээс ажил олгогчдод гологсдоор. Ажил хайж буй төгсөгчдийн 24.4 хувь нь ажлын туршлага дутсан, 19.4 хувь нь ажлын байрны мэдээлэл хомс, 19 хувь нь мэргэжилд тохирох ажил олдохгүй байгааг онцолсон байна.

Уг нь дэлхийн хөдөлмөрийн

зах зээлийн чиг хандлага аж үйлдвэрээс мэдлэгийн эдийн засаг руу чиглэж байна. Мөн шинжлэх ухаан, технологи хурдацтай хөгжиж буйгаас ажлын байранд шинэ ур чадварууд чухал шаардлагатай болсон. Ялангуяа харилцааны ур чадвар, бүтээлч байдал, гадаад хэлний мэдлэг нэн чухалд тооцогдож буй. Гэтэл их, дээд сургуулиудад оюутны

эдгээр чадварыг хөгжүүлэх хөтөлбөрүүд тун маруухан байдаг нь гачлантай.

Дээд боловсрол дэлгүүрийн лангуун дээр өрөөтэй байдаг юм шиг үнэ цэнэ нь унаад олон жил болсон. Ядаж байхад ирэх жилүүдэд ажилгүйдлийн түвшин өсөх төлөвтэй байгаа. Өнгөрсөн онд манай улсад ажилгүйдлийн түвшин 9.5 хувьтай байсан. Харин 2018

болон 2019 онд 10.1 хувьд хүрч нэмэгдэх нь шинэ төгсөгчдийн хувьд тун таагүй мэдээ. Тиймээс дээд боловсролын хөтөлбөр, бодлогод шинэчлэлийн салхи агаар, ус шиг хэрэгтэй байна. Гэхдээ өмнөхөөс нь дордуулчихааргүй, зах зээлийн эрэлтээ мэдэрсэн, төгсөгчдийнхөө ур чадварыг нэмэхэд чиглэсэн өөрчлөлт энэ салбарт хэрэгтэй байна. [ЗГМ]



“ТОРГОНЫ ЗАМ-2018” ШАГНАЛТНУУД ТОДОРЛОО



МҮХАҮТ-аас хоёр жилд нэг удаа зохион байгуулдаг “Silk road” буюу “Торгоны зам” шагнал гардуулах ёслол 2018 оны 2 дугаар сарын 13-нд МҮХАҮТ-ын Их танхимд боллоо.

МҮХАҮТ 2007 оноос Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж байгаа Олон улсын байгууллагууд, хоёр талын техникийн туслалцааны болон гадаадын санхүүжилтээр хэрэгжиж байгаа төслүүд, Дипломат төлөөлөгчийн газрууд, гадаадын хөрөнгө оруулагчид болон гадаадын иргэдийг онцлон шалгаруулах, тэднийг урамшуулан дэмжих, нийтэд таниулах зорилгоор энэхүү арга хэмжээг зохион байгуулсаар ирсэн юм.

Энэ жил нийт 9 номинацид 33 гадаадын хөрөнгө оруулагч, олон улсын байгууллага, Дипломат төлөөлөгчийн газрууд нэрээ дэвшүүлснээс 2016-2017 онд бусдыгаа хошуучилсан доорх нэр бүхий аж ахуйн нэгж, хүмүүс “Silk road Award 2018” шагнал хүртлээ. Үүнд:

Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллагаас:

1. Монгол Улсын болон орон нутгийн төсөвт хамгийн их хувь нэмэр оруулсан гадаадын хөрөнгө оруулагч-Оюу толгой ХХК
2. Шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлсэн хөрөнгө оруулагч-Улаанбаатар Смарт карт ХХК
3. Ногоон хөрөнгө оруулагч- ENGIE ХХК
4. Нийгмийн хариуцлагатай хөрөнгө оруулагч-Мобиком ХХК, “Саусгоби сэнде” ХХК
5. Дотоодын ажлын байр хамгийн ихээр бий болгосон хөрөнгө оруулагч-Е-Mart Hyper Market

Олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүдийн номинациас:

1. Ногоон эдийн засаг, ногоон бизнес, байгаль орчныг хамгаалах чиглэлээр хамгийн өгөөжтэй, үр дүнтэй ажиллаж байгаа-Мон Наран төсөл
2. Ядуурлыг бууруулах, тогтвортой амьжиргааг бий болгох зэргээр нийгмийн хөгжлийг хангахад хамгийн үр дүнтэй ажиллаж байгаа-Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага-Жайка (JICA)
3. Төр, хувийн хэвшлийн харилцан яриа, түншлэлийн механизм, Country Ownership зарчмыг бодитой хэрэгжүүлж буй байгууллага-Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг, Швейцарийн хөгжлийн агентлагийн бэлчээрийн менежментийн төсөл

Хоёр улсын хамтын ажиллагааны хөгжилд хувь нэмэр оруулж буй хүмүүс:

1. Жон Лангтри-Австрали Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд
2. Калыбек Ибрагимович Кобландин - Казахстан Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд
3. Окава Наото-Монгол Японы төвийн Ерөнхий зөвлөх
4. Ялцын Манав-Туркийн тогооч нарын нийгэмлэгийн тэргүүн

ZGM DAILY

UNICEF addresses environmental risk faced by children in UB

UNICEF expects inaction against air pollution to burden the economy by USD 2.4 million from 2021.

Corruption Perceptions Index 2017 released

Mongolia was ranked 103rd with 36 points in 2017.

Southgobi Resources fully pays MNT 35.3 billion tax verdict

CEO of Southgobi Resources LLC meets Deputy Chief of Cabinet Secretariat.

TOP-20 Index falls by 3.38 percent, to 20001.38 points

Market cap stands at MNT 2.4 trillion.

ZGM: HIGHLIGHTS

POLITICS

State Commission on Population and Housing Census 2020 holds its first meeting.

Amnesty International releases annual report 'The State of the World's Human Rights'.

Cabinet orders to urgently relocate offices of the City Council of Ulaanbaatar, Governor's Office and related bodies to Yarmag.

ECONOMY

Feasibility study of an oil refinery in Altanshree soum of Dornogobi aimag is being conducted by India's state-owned company 'Engineers India Limited. It is scheduled to be completed by end of this March.

According to the Bank of Mongolia, capital shortage of commercial banks amount to 2 percent of GDP.

TOP-20 Index falls by 3.38 percent, to 20001.38 points. Market cap stands at MNT 2.4 trillion.

SOCIETY

President of the Mongolian Academy of Sciences Regdel Duger meets Resident Director of the American Center for Mongolian Studies Tricia Turbold.

National Center for Public Health releases Nutrition Status of Mongolian Population report.

Women's Fund of Mongolia launches a 88 day fundraising campaign "Defence of underage sexual assault victims".

Respiratory diseases alarmingly increased in UB

Report on Mongolia's air pollution crisis released

Tugsbilig.B
@tugsbiligZGM

National Center for Public Health and the United Nations Children's Fund (UNICEF) have jointly released "Mongolia's air pollution crisis: A call to action to protect children's health report", addressing the most significant environmental risk faced by children in Ulaanbaatar.

"Air pollution has become a child health crisis in Ulaanbaatar, putting every child and pregnancy at risk. The risks include stillbirth, preterm birth, lower birth weight, pneumonia, bronchitis, asthma and death. It is a real threat to Mongolia's human capital," remarked UNICEF Mongolia Representative Alex Heikens.

The report has estimated how much it costs and how much it will cost health providers to treat air pollution induced diseases in Ulaanbaatar provided the Government of Mongolia does not take immediate action to minimise the current levels of air pollution.

According to the report, incidences of respiratory diseases in Ulaanbaatar alarmingly increased including a 2.7-fold increase in respiratory infections per 10,000 population in the last 10 years. Pneumonia is now the second leading cause for under-five child mortality in the country. Children



Batsaikhan.S / ZGM©

living in a highly polluted district of central Ulaanbaatar were found to have 40 percent lower lung function than children living in a rural area. If the GoM does not take immediate action to address air pollution, the economic burden of air pollution on Ulaanbaatar's health services related to children aged 0-18 years is expected to total MNT 24.8 billion (USD 9.8 million) by 2025. When considering the entire population of Ulaanbaatar, including adults, the annual cost of inaction against air pollution is about MNT 7.2 billion

(USD 2.4 million) on average from 2021 onwards.

In terms of immediate child health measures to consider, the report recommends the following in summary:

- Develop and implement a multi-year public outreach campaign to raise awareness of the dangers of exposure to air pollution (with a focus on pregnant women and young children) and measures people can take to protect their health and

reduce air pollution. This should also include further strengthening the evidence base around child health, pregnancy results and air pollution.

- Vaccinate all new-born children in Ulaanbaatar with 13-valent PCV and include the vaccine in the national immunization schedule of Mongolia and the relevant budget for the National Immunisation Programme budget of the Ministry of Health.

- Develop and implement a comprehensive indoor air quality


management approach for kindergartens, schools and hospitals through a combination of technical and behavior change interventions.

- Develop an advisory note on measures people can take to reduce exposure to air pollution outside, including the proper use of good quality and well-fitted masks; consider the provision of such masks free of charge to the most vulnerable in the communities that are faced with the highest levels of air pollution. [ZGM]

STOCK MARKET


MSE A Index

(Three months to date)




Top 20 Index

(Three months to date)



MSE B Index

(Three months to date)



POLITICS

Mongolia moves down 16 ranks in Corruption Perceptions Index 2017

Tugsbilig.B
@tugsbiligZGM

Transparency International, an international non-governmental organization which is based in Berlin, Germany, has released Corruption Perceptions Index 2017. The index, which ranks 180 countries and territories by their perceived levels of public sector corruption according to experts and businesspeople, uses a scale of 0 to 100, where 0 is highly corrupt and 100 is very clean. Mongolia was moved down 16 ranks to 103rd with 36 points in 2017. This turn of event is almost repetitive as Mongolia fell 15 ranks in the 2016 report. The organization perceived that the score did not improve due to lack of major legal changes against corruption in the last five years.

"CPI results correlate not only

with the attacks on press freedom and the reduction of space for civil society organisations. In fact, what is at stake is the very essence of democracy and freedom," highlighted Delia Ferreira Rubio, Chair of Transparency International.

CORRUPTION INDEX OF MONGOLIA	
2012	36 points
2013	38 points
2014	39 points
2015	39 points
2016	38 points
2017	36 points

TRANSPARENCY INTERNATIONAL CALLS TO TAKE THE FOLLOWING ACTIONS TO CURB CORRUPTION:

- Governments and businesses must do more to encourage free speech, independent media,

political dissent and an open and engaged civil society.

- Governments should minimise regulations on media, including traditional and new media, and ensure that journalists can work without fear of repression or violence. In addition, international donors should consider press freedom relevant to development aid or access to international organisations.


- Civil society and governments should promote laws that focus on access to information. This access helps enhance transparency and accountability while reducing opportunities for corruption. It is important, however, for governments to not only invest in an appropriate legal framework for such laws, but also commit to their implementation.

- Activists and governments should take advantage of the momentum generated by the United Nations Sustainable Development Goals (SDGs) to advocate and push for reforms at the national and global level. Specifically, governments must ensure access to information and the protection of fundamental freedoms and align these to international agreements and best practices.

- Governments and businesses should proactively disclose relevant public interest information in open data formats. Proactive disclosure of relevant data, including government budgets, company ownership, public procurement and political party finances allows journalists, civil society and affected communities to identify patterns of corrupt conduct more efficiently. [ZGM]

MINING

Southgobi Resources announces full settlement of tax verdict



Munkhbat Chuluun, CEO of Southgobi Resources LLC, reports that the company has fully repaid MNT 35.3 billion obligation of the tax verdict during his meeting with Byambasuren Urgamal, Deputy Chief of Cabinet Secretariat.

"The Government of Mongolia issued a resolution on Southgobi Resources LLC to pay MNT 35.5 billion to the State Budget. The resolution obliged us to pay MNT 15 billion in 2016 and 2017 respectively, and the remaining MNT 20.3 billion to be repaid by performing a work in Tavan Tolgoi mine. The company has fulfilled its obligated duties on time," said CEO of Southgobi Resources LLC

and expressed his gratitude towards the Government for supporting the private sector when the company was on the verge of bankruptcy. He added that the company was able to save workplaces of over 400 employees.

Mr. Byambasuren Urgamal remarked "I am grateful that one of the leading tax payers in Mongolia Southgobi Sands has restored its operations, overcoming its difficult period, contributing to the development of provinces and maintaining its position as a socially responsible company in Mongolia."

The company plans to export 5.5 million tons of raw coal and 800 thousand processed coal this year. [ZGM]

Өдрийн хэмнэл

ТВ ХӨТӨЛБӨР



- 09:00** "Людмила Гурченко" Оросын УСК 3, 4 дүгээр анги
- 10:30** "Эе" найрал дууны бүлгэм
- 15:40** "Тэмээ тэшсэн нутгаар" нэвтрүүлэг
- 18:30** Олон нийтийн цаг /шууд/
- 20:00** "Цагийн хүрд" мэдээллийн хөтөлбөр
- 21:05** "Баасан гараг"

Bloomberg TV Mongolia

- 07:00** "Суутнуудын намтар" нэвтрүүлэг
- 11:00** "Made In Mongolia: Монос Фарм ХХК" нэвтрүүлэг
- 14:30** "Танилц: Япон" нэвтрүүлэг
- 18:00** "Бизнесийн төв цэг" давталт
- 20:00** "Блумбергийн ярилцах цаг" нэвтрүүлэг
- 22:00** "Гол сэдэв" нэвтрүүлэг

БОЛОВСРОЛ HD

- 08:05** "Монголчууд ХХ зууны эхэнд" нэвтрүүлэг
- 11:45** Үүнийг хэрхэн хийдэг вэ?
- 14:05** "Яг түүн шиг 2017" шоу нэвтрүүлэг
- 18:05** "Бяцхан оцон шувуу Пороро" хүүхэдэйн кино
- 21:45** Аугаа уран зургууд нэвтрүүлэг
- 23:05** "Их хотын амьдрал" ОАК 6-1, 2 дугаар анги

МОНГОЛTV

- 06:30** "Өнөө өглөө" хөтөлбөр
- 12:30** "M FASHION" 21-15 дугаар хэсэг
- 14:00** "Хүрээлэн амьд ертөнц"
- 17:00** Галилео 51-43 дугаар хэсэг
- 19:30** "Мөрдөгч хүүхдүүд" ОАК
- 22:30** "Өмнө зүгийн хатан хаан" ОАК 13-7 дугаар анги

ЗУРХАЙ



Билгийн тооллын 8
Хаврын тэргүүн хөх бар сарын зургаан цагаан мэнгэтэй улаан нохой өдөр.
Үс засуулбал: Нас уртасна
Наран ургах, шингэх: 07.44-18.25
Барилдлага: Шид
Шүтэн барилдлага: Авахуй
Суудал: Мод

Аргын тооллын хоёрдугаар сарын 23, Сугар гараг. Билгийн тооллын 8, Чөлөөт эх одтой, улаан нохой өдөр.
Өдрийн наран 07.44 цагт мандаж, 18.25 цагт жаргана. Тухайн өдөр морь жилтнээ аливаа үйл хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамагй хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлд шамдах, бүтээл туурвил эхлэх, худалдаа арилжаа хийх, бизнес эхлэх, зэрэг дэвших, угал үйлдэх, хүүхэд үрчлэн авах, гэр байшингийн суурь тавихад сайн. Нүүдэл суудал хийх, хэрүүл тэмцэл хийхэд муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогосод хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал нас уртасна.

ОНЦЛОХ ҮЗВЭР

Ширэнгэд тавтай морил




Одоогоос 23 жилийн өмнө эгч дүү хоёр эртний учир битүүлэг тоглоом олсноор тэдний амьдралд санаанд оромгүй хачин зүйлс тохиолддог. Тэгвэл хачин жигтэй амьтад, бидний төсөөлөө ч үгүй ширэнгэн ойн амьдрал дахин үргэлжилсээр. Ахлах сургуулийн дөрвөн сурагч сахилгын шийтгэл авч, агуулах цэвэрлэх үүрэг хүлээдэг. Тэд агуулахыг нэгжиж байгаад гар удирдлагатай хуучин тоглоом олж, тоглох болно. Гэвч сурагчид

тоглоомынхоо сонгосон дүрд буюу насанд хүрсэн хүмүүс болж ширэнгэн ойд очдог. Тэрхүү ширэнгэн ой ер бусын газар тул тэд аюул, занал, аврал, амь өрсөн тэмцэл гээд санаанд оромгүй зүйлстэй нүүр тулах болно. "Sony pictures"-ийн бүтээл "Ширэнгэд тавтай морил" буюу Жуманжи киноны хоёрдугаар анги IMAX-ийн дэлгэцнээ гарч байна. 90 сая ам.доллараар бүтсэн энэхүү кино өнгөрсөн оны


арванхоёрдугаар сарын 22-нд нээлтээ хийсэн билээ. Киноны найруулагчаар Жейк Касдан ажиллаж, гол дүрүүдэд Двейн Жонсон, Кевин Харт, Жейк Блэк нар тогложээ. Энэ кино гарсан долоо хоногтоо л "Box Office"-ийн жагсаалтыг тэргүүлж, Хойд Америкийн кино театруудаас нийт 27 сая ам.долларын ашиг олсон юм. Харин олон улсаас олсон нийт орлого нь 667 сая ам.доллараар хэмжигдэж байгаа аж. [311]



"Хунт нуур" балет
Хэзээ: 2018.03.04-ний 17.00 цаг
Хаана: УДБЭТ
Тасалбарын үнэ: ₮ 10-30 мянга



"Цагаан Дарь-Эх бурханы насны авшиг" номын айлдвар
Хэзээ: 2018.03.01-ний 10.00 цаг
Хаана: "Буянт Ухаа" спортын ордон
Тасалбарын үнэ: Үнэ төлбөргүй



"Цэлмэг тэнгэрийн од" концерт
Хэзээ: 2018.03.11
Хаана: МҮЭСТО
Тасалбарын үнэ: ₮ 20-25 мянга



"Кармен" дуурь
Хэзээ: 2018.03.10
Хаана: УДБЭТ
Тасалбарын үнэ: ₮ 10-20 мянга




"Бүсгүй минь инээмсэглэж яваарай" тоглолт
Хэзээ: 2018.03.08
Хаана: Улсын филармони
Тасалбарын үнэ: ₮ 25 мянга



"Үйлийн гурван толгой" балет
Хэзээ: 2018.03.03-ны 17.00 цаг
Хаана: УДБЭТ
Тасалбарын үнэ: 10-20 мянга

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ



БОСООГООР:
1. Хүчилтөрөгч
2. Хубилалт хааны ордонд шадарлаж байсан Италийн алдарт аялагч
3. Царцааны төрлийн шавж
6. Японы домогт уул
8. Оройтож төрсөн мал амьтны төл

- 10. Шинэ Зеланд болон Австралийг нээсэн Английн алдарт аялагч
- 11. М.Шолоховын алдарт романд гардаг мөрөн гол
- 4. Давшилт
- 5. Сүг, сүнс
- 7. Агуулах байр сав
- 9. "Цагаан соёт" романы зохиолч
- 12. Эрт үед Монгол нутагт амьдарч байсан аймгуудын нэгэн

ХӨНДЛӨНГӨӨР:

- 1. Засаг захиргааны нэгж




Өмнөх дугаарын хариу / 2.22


ЦАГ АГААР

УЛААНБААТАР

11.23 -11° / -24° 5 м/с	11.24 -8° / -21° 6 м/с	11.25 -3° / -17° 7 м/с	11.26 -9° / -16° 10 м/с	11.27 -13° / -19° 8 м/с
Багавтар үүлтэй	Багавтар үүлтэй	Үүлшинэ	Ялимгүй цастай	Ялимгүй цастай



ЗГМ: КОМИК



ЗГМ: СУДОКУ

			5	2	6			
2			1	3	7	8	6	
						2	5	6
	1	9			5	3	2	
	6		3	8	1			
3		5		9				
9						5	8	3
			2	6		4		
7	1					6		

2	6	7	4	5	8	9	3	1
3	1	9	7	2	6	4	5	8
5	4	8	9	1	3	7	2	6
4	3	1	6	8	2	5	7	9
8	2	6	5	7	9	1	4	3
7	9	5	3	4	1	6	8	2
6	7	2	1	3	4	8	9	5
1	5	3	8	9	7	2	6	4
9	8	4	2	6	5	3	1	7

ГАЛТ ТЭРЭГНИЙ ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-МОСКВА	13.50	14.28
ЭРЭЭН-УБ	18.00	11.15
УБ-БЭЭЖИН	07.15	14.04
ХӨХ ХОТ-УБ	22.50	11.15
УБ-ХӨХ ХОТ	20.00	20.49
УБ-ЭРХҮҮ	21.10	02.40
ЭРХҮҮ-УБ	15.35	06.20
УБ-СҮХБААТАР	21.15	05.12
СҮХБААТАР-УБ	20.55	05.03
УБ-ЭРДЭНЭТ	20.30	07.45
ЭРДЭНЭТ-УБ	19.10	05.48
УБ-ЗАМЫН-ҮҮД	17.20	07.05
ЗАМЫН-ҮҮД-УБ	17.35	08.55

НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-БЭЭЖИН	17.15	19.30
БЭЭЖИН-УБ	20.30	23.00
УБ-ТОКИО	08.55	14.30
ТОКИО-УБ	15.30	20.25
УБ-СӨҮЛ	07.45	12.05
СӨҮЛ-УБ	13.20	16.05
УБ-ХОНКОНГ	07.50	12.25
ХОНКОНГ-УБ	13.25	18.05
УБ-ЭРХҮҮ	09.00	10.30
ЭРХҮҮ-УБ	11.30	13.00
УБ-ХӨХ ХОТ	13.30	16.00
ХӨХ ХОТ-УБ	17.00	19.40

© The Financial Times Limited (2015). All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

Alibaba-гийн зээлжих зэрэглэлд итгэхгүй байна

Alibaba-гийн хэрэгжүүлж буй "нийгмийн итгэл"-ийн зэрэглэлд Хятадын төв банк эргэлздэг. > 10



Польшийн агаарын бохирдол Vogue-ийн нүүрийг барилгав

Сэтгүүлийн нүүр өөрчилсөн нь өвлийн цагт польшууд утаан мананд хэр түгшдэгийн илрэл боллоо. > 10

11. Харин бусад зах зээл тэлж, төв банкууд бодлогын хүүгээ өсгөснөөс иен, евро зэрэг валютын ханш ам.долларын эсрэг чангарч байна.

5. Дэлхий даяар эдийн засаг өсөлттэй, тогтвортой, эрсдэл үүсэх нөхцөл байдал харьцангуй намжмал байна.

6. АНУ-аас бусад эдийн засгийн голлох төвүүдийн капиталын эрэлт нэмэгдэж байна.

7. Дональд Трамп худалдааны протекционист бодлогын тухай байр сууриа улам идэвхжүүлж байна. Худалдааны дайн АНУ-д бараа бүтээгдэхүүний үнэ ханшийг нэмэгдүүлснээр инфляци үүсгэсэн.

8. АНУ-ын Ерөнхийлөгчийн эхлүүлсэн татварын шинэчлэл ам.долларын ханш сулрахад нөлөөлсөн төсвийн алдагдлыг эрчимтэй тэлж байна. 1985 онд Ерөнхийлөгч Роналд Рейган, 2001 онд Жорж Бушийн явуулсан татварын хөнгөлөлтийн үеэр ам.долларын ханш ийм богино хугацаанд суларч байгаагүй.

9. Дональд Трампын засаг захиргаа ам.долларын ханш сулрахыг дэмжсэн. Сангийн сайд Стивен Мнучин Давосын уулзалтад "Худалдааны таатай боломж үүсдэг тул ам.долларын ханш суларч байгаа нь бидний хувьд сайн хэрэг" хэмээсэн юм. Ханшийн уналт гурван жилийн доод түвшинд хүрчихээд байхад Ерөнхийлөгч энэ тухай одоо л ярьж эхэлж байна.

10. Ам.долларын ханш өсөх, буурах шалтгаан юу байв гэх мэтээр зах зээлийн таамаг гаргахад ихээхэн түвэгтэй нөхцөл байдал үүслээ.

Ам.долларын эсрэг евро, иений ханшийн өөрчлөлт



Ам.долларын ханш суларсан 17 шалтгаан

АНУ-ын Сангийн яамны 10 жилийн хугацаатай бондын өгөөж



Ам.доллараар илэрхийлсэн худалдааны индекс



11. БНХАУ бөмбөгөөр харилцаагүй. Харин юанийн ханшийг суллаж, эргээд өсөхийг нь харахдаа таатай байгаа нь мэдээж. Бээжин валютын ханшийн өөрчлөлтөд хөндлөнгөөс нөлөөлөгч гэгдэхээс эмээсэн хэрэг.

12. Төв банкууд валютын нөөцөө ам.доллараас аль болох харааг бус, тусдаа байлгаж эхэлж байна.

13. Бондын өгөөж нэмэгдэж байгаа ч ам.долларыг тэтгэх хэмжээнд хараахан хүрээгүй байна.

14. Хөрөнгө оруулагчид АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн дараа гэнэт өссөн ам.долларын ханшны улмаас хангалттай алдагдал хүлээсэн. Дараа нь Д.Трампын урам хугалсан худалдааны бодлоготой нүүр туллаа. Хөрөнгө оруулагчид дахин ийм "занга"-нд орохыг хүсэхгүй. Тиймээс үр дүнд нь ам.долларын ханш шалдаа буучихаад байгаа нь энэ.

15. Холбооны нөөцийн банк ихэнх хөрөнгө оруулагчдийн хүлээж байгаагаас илүү аядуу байр суурь баримталж байна.

16. Европын төв банк болон Японы төв банк өөрсдийнх нь валют ам.долларын эсрэг чангархаас сэргийлэх арга хэмжээ авах нь утгагүй гэдгийг мэддэг бөгөөд валютынх нь үнэ цэнэ мэдрэгдэх тусмаа сайн.

17. Дональд Трамп АНУ олон улсын тавцанд итгэл даахуйц харагдахаа больсон. Түмэнд нэр хүнд нь сайнгүй Ерөнхийлөгч хэмээн түүхэнд үлдэж буй тэрбээр зэвсэгт хүчнийг хариуцлага гэж үздэг ч ам.долларын ханшаа барьж чаддаггүй.

Оросын эрүүл мэндийн үйлчилгээнд хувийн хэвшил давамгайлах болов

Хэнри Фой

ЗХУ задарснаас хойш 26 гаруй жил өнгөрөхөд Оросын дундаж анги Европ тивийнхний гаалдаг олон тав тухыг эдэлдэг боллоо.

Худалдааны төвүүдэд дэлхийн нэртэй сүлжээ дэлгүүрүүд байраа эзэлж, хотын төвийн гудамжийг гадаадын автомашинууд түгжрээж байна. Олон улсын аялал жуулчлал дээдсийн хүртэл байгаа больж, Москвагийн Икеа дэлгүүрт аймшиггүй нэг нь орж зүрхэлдэг байсан үе ард хоцров. Харин бизнесийн нөхцөл боломж нь сайжирсаар буй Оросын дундаж анги эрүүл мэндийн үйлчилгээ одоогоос л хүртээмжтэй болов.

ОХУ-ын 2.2 их наяд рублийн (39 тэрбум ам.доллар) үнэлгээ бүхий эрүүдийг хамгаалах зах зээлд төрийн мэдлийн эмнэлэг, даатгалын тогтолцоо ноёрхдог. Эдүгээ төрийн энэхүү тогтолцооны төсөв хомсдож, ачаалал хэтэрлээ. ОХУ-д 10 мянган хүнд оногдох эмнэлгийн орны тоо 1990 онд 137 байсан бол 2015 онд 84 болж цөөрчээ. Мөн хугацаанд клиник эмнэлгийн тоо 35 мянгаас 23 мянга хүртэл уруудсаныг аудитын КРМГ компанийн тайлангаас үзэж болно.

Оросууд урт насалж, цөөн хүүхэд төрүүлдэг болов. Ирэх зургаан жилд хөдөлмөрийн насны хүн амын тоо бараг 10 хувиар багасах тооцоог ОХУ-ын эдийн засгийн сайд Максим Орешкин дурдлаа. Нэг хүнд ногдох төрийн зардалд дарамттай уг бууралт "эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжид сөргөөр нөлөөлж болзошгүй"-г тайланд анхааруулжээ.

Үүний зэрэгцээ дундаж анги цоо шинэ iPhone, импортын хүнстэйгээ нийцэхүйц өрнөдийн

эм, эмчилгээний стандарт шаардах нь ихсэж байна. Эрүүл мэндийн хувийн үйлчилгээний зардал сүүлийн 14 жилд 10 дахин өсөж, нийт зах зээлийн бараг гуравны нэгийг эзлэх болсонд гайхалтгүй. Мөн жил бүр 500 мянга гаруй орос хүн мэс засал тийлэх, эмчлүүлэхээр хилийн чанадыг зорьж байна.

Нэг хүн эрхэлдэг клиник, нэгдсэн системд үл хамаарах тусдаа эмнэлгүүд давамгайлдаг хувийн зах зээлийн тархай байдал, өсөх ирээдүй нь улсын хэмжээний сүлжээ байгуулах арга эрэлхийлэгч компаниудын хөрөнгө оруулалт татдаг боллоо.

"ОХУ-ын төрийн мэдлийн эрүүл мэндийн тогтолцооны шилдэг зүйлсийг Европ, АНУ-ын шилдэг зүйлстэй нэгтгэх замаар шинэ тогтолцоо үүсгэх"-ээ тус улсын эрүүдийг хамгаалах салбарын хувийн үйлчилгээ бүрдүүлнэ. Тус компани АНУ, Европ, Өмнөд Солонгосын хэд хэдэн компанитай яриа хэлэлцээ өрнүүлж буйг тайлбарласан ноён Сиразудтинов "Эмч нарыг Орост авчирч, эмчилгээний жуулчлал хөгжүүлнэ" хэмээн өгүүллээ.

"Гадаадад эмчлүүлснээс хямд, дээр нь олон хүн хамарна" хэмээн тэрбээр тайлбарлав. Оросын эрүүл мэндийн зах зээл дэх энэ их хөрөнгө оруулалт эрсдэлтэй. Гадаадад эмчлүүлдэг оросууд ямар ч орчин үеийн технологитой байлаа гээд дотоодод эмчлүүлэх сонголтыг эс хэрэгсэх юм уу дурамжхан ханддаг. Гэхдээ л эрүүдийг хамгаалахад зориулдаг төрийн зардлыг ихэссээр буй хэрэгцээ шаардлагад нийцүүлэхээр чармайж, дундаж анги чинээлэгжсээр буй үед эрүүл мэндийн зах зээл халаас түнтгэр бизнесийхэнд шинэ боломж олгож байна.

ОХУ-ын эрүүл мэндийн зах зээлд байр сууриа эзлэх нь амаргүй ажил. Medsi

хоёр жилийн өмнө Москвад эмнэлэг байгуулахад 4.3 тэрбум рубль буюу 760 сая ам.доллар зарцуулжээ. Гэхдээ үйлчилгээний орлого жил бүр 30 орчим хувиар өсөж байгаагаас бусад тоглогч ч жишгийг дагаж байна. Нөхөн үржихүй, төрөлт, эхийн асаргаа үйлчилгээний "Эх, хүүхэд" хөтөлбөр хэрэгжүүлдэг ОХУ-ын 34 эмнэлгийн орлого 2014-2016 оны хооронд 72 хувиар өсөв. Эрүүдийг хамгаалах үйлчилгээний хувийн "Чайка" компани Москва орчимд таван эмнэлэг ажиллуулж байна.

Medsi нь Москва орчмын эм, эмчилгээний парктаа суурилан үйл ажиллагаагаа гадаадад тэлэх эрмэлзэлтэй. Ирэх оноос ажиллах тус парк олон улсын эмнэлгүүдэд ОХУ-ын лицензээр салбараа нээх, оросуудад гадаадын эмчид үзүүлэх нөхцөл бүрдүүлнэ. Тус компани АНУ, Европ, Өмнөд Солонгосын хэд хэдэн компанитай яриа хэлэлцээ өрнүүлж буйг тайлбарласан ноён Сиразудтинов "Эмч нарыг Орост авчирч, эмчилгээний жуулчлал хөгжүүлнэ" хэмээн өгүүллээ. "Гадаадад эмчлүүлснээс хямд, дээр нь олон хүн хамарна" хэмээн тэрбээр тайлбарлав.

Оросын эрүүл мэндийн зах зээл дэх энэ их хөрөнгө оруулалт эрсдэлтэй. Гадаадад эмчлүүлдэг оросууд ямар ч орчин үеийн технологитой байлаа гээд дотоодод эмчлүүлэх сонголтыг эс хэрэгсэх юм уу дурамжхан ханддаг. Гэхдээ л эрүүдийг хамгаалахад зориулдаг төрийн зардлыг ихэссээр буй хэрэгцээ шаардлагад нийцүүлэхээр чармайж, дундаж анги чинээлэгжсээр буй үед эрүүл мэндийн зах зээл халаас түнтгэр бизнесийхэнд шинэ боломж олгож байна.

STUDIO | 1.0

Bloomberg TV MONGOLIA



Studio 1.0 нэвтрүүлгийн энэ удаагийн зочноор SoftBank-ийн ерөнхийлөгч асан, Google-ийн бизнес хариуцсан захирлаар ажиллаж байсан Никеш Арора оролцох болно. Soft Bank гэх эзэнт гүрний өв залгамжлагчаар нэрлэгдэж байсан Никеш Арора Энэтхэгт агаарын цэргийн албан хаагчийн гэр бүлд төрж өссөн. Бакалаврын зэрэг эзэмшсээр АНУ-ыг зорьсоноор 2004 онд амьдралыг нь бүрмөсөн өөрчилсөн ажлыг хүлээн авав. Ларри Пейж, Сергей Брин нар Google компани онлайн сурталчилгааны магнат болгоход туслуулах зорилгоор Арораг ажилд авсан юм.

Даваа гараг /2018.02.26/

20:30

11:30 Мягмар гараг /давталт/

Амралтын өдрүүдээр /давталт/



© The Financial Times Limited (2015). All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

Жон Гаппер

Alibaba группийн төлбөрийн үйлчилгээний Ant Financial салбар хувьцаагаа нийтэд нээлттэй арилжиж хөрөнгийн үнэлгээ нь 120 тэрбум ам.доллар давах аваас Goldman Sachs-аас ч үнэ цэнэтэй болно. Ant-ын мобайл төлбөрийн инновацлаг, үнэ цэнэтэй платформ – Alipay зээлжих зэрэглэлийн шинэ арга боловрууллаа.

АНУ-ын FICO, ХБНГУ-ын Schufa зэрэг уламжлалт зээлжих зэрэглэлтэй өрсөлдүүлэн Alipay-д ашиглах Sesame Credit нь тун өвөрмөц. Учир нь уг зэрэглэл худалдан авагчдын дадал зуршил, нийгмийн хүрээ, урьд өмнөх зээлийн түүх зэргийг хянах аргаар зээлийн ажиллагааг хөгжиж буй зах зээлд өргөжүүлэх зорилготой.

Гэхдээ уг зэрэглэл бэрхшээлтэйг БНХАУ өөрөө ч хүлээн зөвшөөрдөг. Alibaba, түүний өрсөлдөгчдийн хэрэгжүүлж буй “нийгмийн итгэл”-ийн зэрэглэлд тус улсын төв банк эргэлздэг. Sesame Credit-ийг бусад зэрэглэлээс онцгойлон улс даяар сурталчлахаа зогсоохыг төв банк энэ сард Tencent-ээс шаардлаа. Уг нь 2015 онд төв банк уг зэрэглэлийг нэвтрүүлэх ажлыг дэмжиж байсан юм.

Хятад улс 2020 он гэхэд иргэдийнхээ үйл ажиллагааг хянаж, “итгэлтэйг нь урамшуулан, итгэлгүйг нь арга хэмжээ авах” өргөн цар хүрээтэй төлөвлөгөө дэвшүүлээд байгаа. Тус улсын иргэдтэй холбоотой хувийн зээлжих зэрэглэлийн систем улам бүр Орвеллын “нийгмийн итгэлийн тогтолцоо”-той төстэй боллоо. Торгуулсан, автобусны тасалбар аваагүйнхээ төлөө хятад иргэд ажил эрхлэх, аялан зорчих эрхээ ч хязгаарлуулах аюултай тулгарав.

Sesame болон түүнтэй төстэй зээлжих зэрэглэлүүд Хятадын төрийн төлөвлөгөө шиг хорлонг эд биш. Зээлжих зэрэглэл нь арилжааны ажиллагааг хөнгөвчлөх л зорилготой. Sesame нь хэрэглэгчийн зөвшөөрөлгүйгээр хувийн өгөгдлийг засгийн газруудтай хуваалцахгүй гэдгийг Alipay тайлбарладаг. Гэхдээ л ийм зэрэглэлд өчнөөн цоорхой бий.

Юун түрүүнд ийм зэрэглэлийг банкт харьцуулахад өгөгдөлд харьцангуй сул ханддаг технологийн компаниуд бүтээсэн. Банкууд өөрсдөө найдвартай гэж тооцсон хүмүүст зээл олгодог “нийгмийн нягтлан”-гийн үүрэг гүйцэтгэж байгааг 30 жилийн тэртээ АНУ-ын эдийн засагч, Нобелийн шагналт Жозеф Штиглиц тайлбарлаж байв. Харин технологийн компаниуд ийм үүргийг арай сул гүйцэтгэдэг.



BBM©

Alibaba-гийн зээлжих зэрэглэлд итгэхгүй байна

Банкууд үйлчлүүлэгчдийнхээ зарцуулалт, хувийн дадал зуршилтай холбоотой асар их өгөгдөл хадгалдаг ч зохицуулалт, ур чадваргүй байдал, нууцлал сахиу уламжлалаа захирагдан бололцооноосоо бага ашигладаг. Зээлийн шийдвэр гаргахдаа банкууд салбарынхаа стандарт өгөгдлийг л ашигладаг нь хачирхалтай.

Харин технологийн компаниуд өөрсдөдөө байгаа өгөгдлийн нууцлалыг нь сахин мөрдөж байгаад бүгдийг ашиглах хандлагатай. Үүнд хүмүүсийн гар утаснаас гадагшилж буй бүх өгөгдөл-байршил төдийгүй олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хүрээ, худалдан авч буй бараа, үйлчилгээ хүртэл багтана. Ийм өгөгдлийг буруугаар ашиглах

боломж, зохицуулалт нь санхүүгийн салбарынхаас сул.

Хоёрдугаарт, гүйлгээний тоо, давтамжаар нь зээлийг үнэлэхэд түлэх дайвар нөлөөг тооцоо ёстой. Нэг нь бага зээлж, хяналт тавих замаар уламжлалт зээлийн үнэлгээг өсгөж болно. Гэтэл итгэлийн зэрэглэл нь үүнээс эсрэг буюу хэрэглэгч нар интернет платформ ашиглан аль болох ахиу худалдан авах, түрээслэх, идэвхтэй, үнэлгээ сайтай бүлгийн хүрээ үүсгэхэд түлхэж байдаг.

“Нийгмийн итгэлийн зэрэглэл” нь олон нийтийн сүлжээний санхүүгийн хувилбар, мобайл гэйм ашигладаг идэвхтэй ажиллагааны явцад оноогоо өсгөхийг хүмүүст шахаж байдаг тоглоомжсон тэмцээн юм.

Уламжлалт зээлжих зэрэглэлтэй харьцуулахад ийм зэрэглэлийн дүрэм ч бүрхэг. Хэрэглэгчдийн байрыг тодорхойлох 350-аас 950-ын хоорондох оноог Sesame-ийн алгоритм хэрхэн тооцоолохыг хэн ч мэдэхгүй.

Гуравдугаарт, АНУ-ын зээлийн гурван том хороо, бүх банк ашигладаг FICO онооноос ялгаатай нь “нийгмийн итгэлийн зэрэглэл” өмчлөгчтэй, өрсөлдөөнтэй. Sesame оноогоо ихэсгэх гэвэл хэрэглэгч Alipay шийдвэр зэрэглэл” өмчлөгчтэй, өрсөлдөөнтэй. Sesame оноогоо ихэсгэх гэвэл хэрэглэгч Alipay шийдвэр зэрэглэл” өмчлөгчтэй, өрсөлдөөнтэй.

Төлбөрийн платформ, зээлийн зэрэглэлийн шүүгч болох аль ч тохиолдолд ашиг сонирхлын илт зөрчил үүсэж байна. Зээлийн онооны алгоритмд жижиг засвар

оруулахад л үйлчлүүлэгчдийн гүйлгээ ихсэж болно. Өрсөлдөгч технологийн компаниудад зээлийн зэрэглэл үүсгэх эрх олгосон нь учир дутагдалтай шийдвэр болсныг Хятадын төв банк оройтож ойлгожээ.

Ийм учраас хүн бүр нэр хүндийг нь төдийгүй, зээл авах боломжийг нь тодорхойлох оноотой болохоос өмнө “нийгмийн итгэлийн зэрэглэл”-ийг сайтар судлах шаардлагатай. “Иргэн бүрт амьдралыг үндсээр нь өөрчлөх оноотой болох тийм зах зээл үүснэ” хэмээн Берлин дэх Хүний хөгжлийн Макс Планкийн хүрээлэнний эрдэмтэн Герд Гигереншер тайлбарлав.

Дижитал иргэн бүрийн үүсгэж буй өгөгдлийн найдвартай хамгаалах нэг арга бий. Энэ нь

өгөгдлийг засгийн газар, компаниуд бус, иргэдэд өөрсдөд нь хадгалуулах. Хүмүүс социал болон төлбөрийн платформоор үйлчлүүлдэг, хувийн мэдээллээ брэндүүдэд булаалгасан үйлчлүүлэгч байхын оронд өгөгдлөө өөрсдөө хадгалах хэрэгтэй.

Уламжлалт зээлжих зэрэглэл ч ийм маягаар ажилладаг. Үйлчлүүлэгч банкаа солилоо ч оноо нь хэвээр. Энэ тавдугаар сараас үйлчилж эхлэх Европын холбооны “Өгөгдөл хамгаалах ерөнхий зохицуулалт”-аар (General Data Protection Regulation) хэрэглэгч аливаа компанид хадгалж буй өгөгдлөө өөр үйлчлэгч компанид шилжүүлэх эрх эдлэхээр заажээ.

FT

Польшийн агаарын бохирдол Vogue-ийн нүүрийг барайлгав

Жэймс Шоттер

Vogue сэтгүүлийн польш хэвлэлийн шинэ дугаарын хавтаснаа тус улсын шилдэг хоёр загвар өмсөгч гарчээ. Гэхдээ өнгөрсөн долоо хоногт уншигчдын нүдийг загвар өмсөгч нар бус, тэдний арын ордыг бүрхсэн утаан хөшиг татав.

Хэдхэн цагийн дараа Польшийн олон нийтийн мэдээллийн хэрэгсэл хавтсанд өөрчлөлт оруулж “Vogue”-ыг “Smogue” болгов. Нийгэд тархсан нэгэн хувилбарт арын барилгын наана амны хаалт зүүсэн гурван бүсгүй бүхий өнгөлөг бус зургаар солилоо.

Уг үйлдэл нь жилийн энэхүү цагт польшууд утаа мананд хэр түгшдэгийн илрэл боллоо. Европ дахь агаарын бохирдол ихтэй 50 хотын 33 нь Польшид оршдогийг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын 2016 оны тайлангаас үзэж болно. Өвлийн саруудад тус улс Европын агаарын чанарын стандартыг байнга зөрчсөөр ирлээ.

Нэгдүгээр сард Варшавын агаар хүүхдийг бадаа бус аль болох дотор байхыг зөвлөх хэмжээнд хүрэхээр бохирддог.

Утааны хэмжээ мэдэгддэг аппликэйшнээ өглөө бүр шалгаж байхыг сайхан сэтгэлийн үүднээс өөрт минь зөвлөсөн польшууд тоогоо алдсан.

Эхүүн утаанд Польшийн том хот, аж үйлдвэрийн төвүүд л өртөөд байгаа хэрэг бус. “Пиениний байгалийн цогцолборт газраар хэдийн жилийн өмнө явж үзсэн. Жин үд орчим агаар тунгалаг. Харин үдээс хойш хөндий уруудах үеэр гэнэтхэн бөөн хар үүл харсан”-аа Client Earth хүрээлэн буй орчинг хамгаалах группийн Илона Йедрашик дурсав.

“Цогцолборт утаа байж таарахгүй гэж бодлоо. Гэтэл утаа байж. Буцах үед бидний хувцас түүдгийн хажууд зогссон аятай харласан байлаа. Цочирдом хэрэг” хэмээн тэрбээр өгүүлсэн юм. Бохирдлын гол шалтгаан нь орон сууцны халаалтын систем. Өвөл ачаалал ихэсдэг автозамын хөдөлгөөн, үйлдвэрүүдийн ажиллагаа ч нэрмээс болно. Мөнгөө хэмнэхийн тулд зарим оршин суугч мод, нүүрснээс авхуулаад нүүрсний нунтаг, хог хүртэл түлнэ. Хог шатаахыг хориглодог ч Польшид холбогдох хуулийн хэрэгжилт сул.

Notes from Poland  @notesfrompoland [Follow](#)

Someone's improved the first cover of the new @VoguePoland #smogue #smog



SMOGUE POLSKA

4:57 AM - 13 Feb 2018

27 Retweets 65 Likes 

Polski Alarm Smogowy and SmogLab

27 65

Утааны ялгаралд тавьдаг шаардлагад нийцээгүй зуух борлуулахыг Польшийн засгийн газар жилийн өмнө хориглосон төдийгүй Краков зэрэг зарим хотод нүүрс, мод түлдэг бүх зуухыг солих шаардлага тавьжээ. Гэхдээ л утааг багасгах гэвэл илүү ихийг хийх шаардлагатайг хүрээлэн буй орчныг хамгаалагч нар өгүүлж байна.

“Улс даяар гурван сая зуух байгаа нь бэрхшээл” хэмээн агаарын бохирдолтой тэмцэх Smogathon санаачилга өрнүүлэгч Мачей Риш тайлбарлав. “Муу нүүрс, резин дугуй, хог гээд юу ч шатааж болно, шатааж ч байгаа. Энэ бэрхшээл ялангуяа тосгодог тод. Энэ зуршлаас салахгүй л бол утаа арилахгүй”.

Айл өрхөд борлуулдаг нүүрсэнд чанарын стандарт тогтоох нь чухлыг агаарын чанар сайжруулах кампани өрнүүлэгч Polish Smog Alert байгууллагын Анжей Гула өгүүлэв.

“Шатахуун түгээх станцаар үйлчлүүлэгч ямар шатахуун авч байгаагаа мэдэж байдаг. Харин зуух юм уу бойлероо шатаах нүүрс авч байгаа хүн ямар ч

ойлголтгүй. Юу ч зарж болдог” хэмээн тэрбээр тайлбарласан юм.

Польшийн засгийн газар олборлодог цул түлшинд стандарт тогтоохоор амласан ч таг чиг. “Одоогийн ч, өмнөх засгийн газраас ч адилхан. Олон жил болж байгаа асуудал. Бэрхшээлийн шалтгаан нь нүүрсний лобби. Үе үеийн засгийн газар нүүрсэнд стандарт тогтоохоос эмээж ирлээ” хэмээн хатагтай Йедрашик яриу.

Ухаалаг санал санаачилга хэрэгтэйг ноён Гула анхааруулав. Малопольска бус нутагт хуучин бойлерыг зохицуулалтгүйгээр шинэчлэх ажилд татаас олгосон нь зах зээлийн шинэ мөртөө бохирдолтой бойлероор дүүргэснийг тэрбээр жишээ татлаа.

Зохицуулалт дутагдсанаас үүдэлтэй бохир агаарын горьг польшууд халаас, уушги хоёророо мэдэрсээр байх болно. Польш улс Европын холбооны агаарын чанарын дүрэм журмыг зөрчсөн эсэхийг пүрэв гарат Европын шүүх тогтооно. Польш буруутгах аваас овоохон торгуулж мэдэх юм.

FT

Эдийн засаг

1072 ширхэг хувьцаа энэ онд амилах нь эргэлзээтэй



С.Батболдын Засгийн газар 2011 онд иргэдэд 1072 ширхэг хувьцаа эзэмшүүлэх түүхэн шийдвэр гаргаж байлаа. Хувьцааны нэрлэсэн үнийг 933 төгрөгөөр тогтоож, “Эрдэнэс Тавантолгой”-н 14 хувь олон нийтийнх болсон түүх эндээс эхтэй.

С.Батсайхан / ЗГМ ©

Дотоодын хөрөнгийн биржид хувьцаагаа бүртгүүлснээр үнэлгээ тодорхой болно

Мөн Хөгжлийн банкнаас олгосон 200 сая ам.долларын зээлээс 100 сая ам.долларыг зээлийн эргэн төлөлтийг хуваарьг хугацаанаас нь өмнө төлсөн. Өр, зээл нь нимгэрч, үйл ажиллагаа нь жигдэрч эхэлсэн “Эрдэнэс Тавантолгой”-н 2017 оны ашиг түүхэн дээд хэмжээ болж байна.

Монголын нүүрсний 30 хувийг дангаараа гаргадаг тус компани өнгөрсөн онд 11 сая тонн нүүрс экспортолгоо гэж төлөвлөснөөс есөн сая тонныг экспортолсон. Тэгвэл энэ онд 10 сая тонныг гаргахаар төлөвлөж байна. Санхүүгийн үзүүлэлт нь сайжирч, зах зээл ивээж байгаа нь хөрөнгийн зах зээлд хөл тавих итгэл өгчээ. Эргэн сануулахад, С.Батболдын Засгийн газар 2011 онд иргэдэд 1072 ширхэг хувьцаа эзэмшүүлэх түүхэн шийдвэр гаргаж байлаа. Хувьцааны нэрлэсэн үнийг 933 төгрөгөөр тогтоож, “Эрдэнэс Тавантолгой”-н 14

хувь олон нийтийнх болсон түүх эндээс эхтэй. Тус компани олон улсын зах зээлд хувьцаагаа энэ онд гаргахад ямар бэрхшээл, сорилт хүлээж байна вэ. Үүнийг хөрөнгийн зах зээлийн шинжээчид хэрхэн дүгнэж байгааг уншигч танд хүргэе. [ЗГМ]

Б.Мөнх
ЗГМ

БАЙР СУУРЬ



“Эрдэнэс Тавантолгой”-н хувьцаа эдийн засгийн эргэлтэнд орох ойртож байгааг тус компанийн гүйцэтгэх захирал Д.Ариунболд энэ сарын эхээр мэдэгдсэн. Тэрбээр иргэдийн 1072 ширхэг хувьцааг амь оруулах бэлтгэл ажил эхэлсэн гэдгийг зарласан бол салбарын сайд Хонконгийн хөрөнгийн бирж дээр гаргахаар төлөвлөж байгааг нэмж дуулгасан. Тодруулбал, энэ оны гуравдугаар улиралд багтаж “Эрдэнэс Тавантолгой” олон улсын хөрөнгийн зах зээлд гарах нь.

Урьдчилсан мэдээллээр 2.2 сая хувьцаа эзэмшигчтэй тус компани өнгөрсөн онд улсад 400 орчим тэрбум төгрөгийн татвар төлж, 250 гаруй тэрбум төгрөгийн ашигтай ажилласан. Үүнээс гадна таван жилийн турш үргэлжилсэн БНХАУ-ын “Чалько” компанийн өрийг бүрэн барагдуулж дууссан.



ЦАГ ХУГАЦААНЫ ХУВЬД 2018 ОН ЗОХИМЖТОЙ

А.Билгүүн /MIBG үнэт цаасны хөрөнгө оруулалтын компанийн гүйцэтгэх захирал/

“Компани бүтцийн өөрчлөлт хийж, үндсэн үзүүлэлтээ сайжруулах ёстой. Бүтцийн өөрчлөлт хийхэд компанийн засаглал, санхүүгийн тайлагнал, үндсэн үйл ажиллагааны тайлагнал чухал. Мөн гадаадын хөрөнгийн биржийн шаардлагыг хангаж байна уу. Шаардлага хангаж байж л тухайн зах зээлээс хөрөнгө оруулагчдаа олох ёстой. “Эрдэнэс Тавантолгой” шаардлагыг нь хэр хангаж байгааг мэдэхгүй юм. Бидэнд байгаа мэдээллээр 2018 онд багтаж гарна гэж хэлэхэд хүнд. Бүтцийн өөрчлөлтөөс энэ бүхэн шалтгаална.

Нүүрсний үнэ харьцангуй тогтвортой, сайн байгаа гэдгээрээ санхүүгийн өгөөж сайтай байх магадлалтай. Тиймээс цаг хугацааны хувьд 2018 он зохимжтой.

ХАМГИЙН БАГАДАА ЗУРГААН САРААС НЭГ ЖИЛ ХҮРТЭЛХ ХУГАЦАА ШААРДАГДАНА

Б.Өлзийбаяр /Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга/

“Эрдэнэс Тавантолгой” компани иргэд, аж ахуйн нэгжид эзэмшүүлсэн компанийнхаа 14 хувьтай тэнцэх хэмжээний хувьцаагаа дотоодын хөрөнгийн биржид юуны өмнө бүртгүүлэх хэрэгтэй. Энэ нь Монголын хөрөнгийн биржид данстай болно гэсэн үг. Үүний дараагаар олон улсын хөрөнгийн зах зээлд IPO гаргах нь илүү үр дүнтэй. Дотоод болон гаднын хөрөнгийн биржид гарахад бэлтгэл ажилд маш их цаг хугацаа орно. Хамгийн багадаа зургаан сараас нэг жил хүртэлх хугацаа шаардагдана. Хувьцаагаа дотоодын биржид бүртгүүлснээр компанийн үнэлгээ тодорхой болж эхэлнэ. Хувьцаа эзэмшигчдийн бүтцээ цэгцэлж байж IPO амжилттай гарах боломжтой.

ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ

Ипотекийн зээлд шинээр 497 иргэн хамрагджээ

Б.Тулгат
ЗГМ

Ипотекийн зээлийн үлдэгдэл 4.3 их наяд төгрөгт хүрч, нийт зээлдэгчийн тоо 93 мянгыг давлаа. Энэ он гарсаар арилжааны банкууд 497 зээлдэгчид 34.9 тэрбум төгрөгийн зээл шинээр олгосныг Монголбанкнаас мэдээллээ. Нэг зээлдэгчид дунджаар 70.3 сая төгрөг ногдсон байна. Ипотекийн зээлийн үлдэгдлийн 60.3 хувь буюу 2.5 их наяд төгрөгөөр 2011-2015 онд ашиглалтад орсон орон сууц худалдан авчээ. Зээлдэгчдийн 64 хувь нь хоёр сая хүртэлх төгрөгийн өрхийн орлоготой байна. Үүний 73 хувь нь Улаанбаатар хотод байршилтай орон сууц худалдан авсныг төв банкны албан мэдээлэлд дурджээ. ОУВС-гийн “Өргөтгөсөн

санхүүжилтийн хөтөлбөр”-г Монгол Улс хамрагдсантай холбогдуулан ипотекийн зээлийн хөтөлбөрийг төсвийн шинжтэй санхүүжилт гэж үзсэн. Тиймээс ипотекийн зээлийг Монголбанкны эх үүсвэрээр санхүүжүүлэхийг хязгаарласан.

Иймээс уг зээлийг Засгийн газар өөрийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр болж, 2017 оны төсвөөс 111 тэрбум төгрөг, Монголбанкнаас зээлийн үндсэн төлөлтийг буцаан таталгүйгээр 192 тэрбум төгрөгөөр ипотекийн зээлийг дахин санхүүжүүлсэн. Энэ оны тухайд Засгийн газраас 120 тэрбум төгрөг, Монголбанкны зээлийн эргэн төлөлтөөс 180 тэрбум төгрөг санхүүжүүлэхээр төлөвлөсөн. Засгийн газраас ипотекийн зээлийн урьдчилгаа болон найман хувийн хүүг нэг хувиар бууруулахаар судалж байна. [ЗГМ]

НОМИН ХОЛДИНГ

“Хөвсгөл усан зам” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2018 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 10:00 цагт Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэр, Номин юнайтед цогцолборын 6 давхрын хурлын танхимд болно.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал:

- Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, түүний талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлт, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн болон гүйцэтгэх удирдлагын 2017 оны ажлын тайлан
- Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх аудитын хорооноос санхүүгийн тайланд хийсэн дүгнэлт
- Компанийн эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор авсан зээлийн талаарх танилцуулга
- Компанийн ногдол ашгийн талаар гаргасан Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэрийг танилцуулах

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдөр 2018.02.26-ны өдрөөр тасалбар болно.

Хурал зохион байгуулах комисс
Утас: 99042205

ЗГМ ТОВЧХОН

» АРИЛЖАА

Монголын хөрөнгийн биржийн пүрэв гарагийн үнэт цаасны арилжаагаар 29 хувьцаат компанийн 247,580 ширхэг хувьцаа арилжааллаа. Энэ өдөр найман компанийн хувьцааны ханш өсөж, 18 компанийнх буурсан бол гурван компанийнх тогтвортой байлаа. Үүнээс “Евроази Капитал Холдинг” болон “Түшиг Уул”-ын хувьцааны ханш хамгийн өндөр өсөлттэй байв.

» ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

197.5

Сая төгрөг. Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн багцын арилжаагаар 1997 ширхэг үнэт цаасыг 197.5 сая төгрөгөөр арилжаалав.

» КОМПАНИ

“Баян Тээг” хувьцаат компани 2017 оны цэвэр ашгийн дүнгээс нэгж хувьцаанд 100 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэлээ.

» ТӨСӨВ

77.2

Хувь. Улсын нэгдсэн төсвийн орлогын 77.2 хувийг татварын орлого бүрдүүлж байна.

» БАНК, САНХҮҮ

13

Хувь. Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2018 оны нэгдүгээр сард 1.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 13 хувиар өсчээ.

» ХУДАЛДАА

77.1

Мянга. Улсын хэмжээнд 77.1 мянган аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс 29.9 мянга нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт төвлөрчээ.

» МОНГОЛБАНК

6.9

Хувь. Инфляцын төлөв байдлын ээлжит тайланг өнөөдөр төв банкнаас олон нийтэд танилцуулна. Улсын хэмжээнд инфляц 6.9 хувьтай тэнцэж байна.

» АЖ ҮЙЛДВЭР

Газрын тосны боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан ТЭЗҮ-г Энэтхэгийн төрийн өмчит EIL компани хийж байна. ТЭЗҮ-г ирэх сарын эцэст Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам хүлээж авна.

» ТЭЭВЭР

44.4

Тэрбум төгрөг. Төмөр замын тээврийн салбарын орлого өнгөрсөн сард 44.4 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 10.3 тэрбумаар өсчээ.

ВАЛЮТЫН ХАНШ

АНУ доллар	2,398.35
Евро	2,941.70
Япон иен	22.32
ОХУ рубль	42.24
БНХАУ юань	377.03
БНСУ вон	2.21

Эдийн засаг

Шинэ журам ломбардуудыг цэгцэлж чадсангүй

Үйлчлээд удаагүй шинэ журам цаасан дээр үлдээж мэдэхээр байна



"MNS 5274-2017" стандартад ломбардуудыг зөвхөн ажлын цагаар ажиллуулахаар тусгасан. Насанд хүрээгүй хүүхдэд үйлчлэх, хотын хөдөлгөөн ихтэй бүсэд ломбардын үйлчилгээ явуулахыг хоригложээ.

С.Батсайхан / ЗГМ©

Гудамжны булан тохой бүрт салбараа нээж, Монголын хот суурингуудыг үл үзэгдэх тороор хэрээр байгаа эдгээр бичил тоглогч "Биднийг хэн ч хянадаггүй" гэсэн шиг дураараа дургиж, ядарсан, мөнгө яаралтай хэрэг болсон иргэдийг хүүлж, олон монгол хүнийг өрийн хэлхээнд хүлээж байна. Монголын төр 30-аад жил ломбардуудын толгойг илж, тодорхой журам, тогтсон байгууллагын хяналтад оруулаагүйгээс эдгээр хүүлэгч эмх замбараагаа алдчихаад байгаа.

Манай сонин ч барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ буюу ломбардууд дүрэм журамгүй зохицуулалтын цоорхойд хэрхэн буглаж, эрээ цээрээ алдаж буйг хөндөн, цуврал хэд хэдэн сурвалжилга, нийтлэл хүргэсэн. Эдгээр нийтлэлийн дараагаас ломбардтай холбогдсон дүрэм журмыг холбогдох байгууллагууд шинэчилж эхэлсэн. НЗДТГ, нийслэлийн Цагдаагийн газар, Стандарт хэмжилзүйн газар, Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах холбоо, ШӨХТГ-аас хамтран барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаанд тавих журмыг шинэчилсэн.

Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй ломбардуудад хамаарах энэ журмыг 2018 оны нэгдүгээр сарын 1-нээс хэрэгжүүлэхээр болсон юм. Уг журамд

зах замбараагаа алдсан занхгар ломбардуудыг чиглэсэн хэд хэдэн заалт багтсан. Тухайлбал, "MNS 5274-2017" стандартад ломбардууд шөнө оройгоор бус зөвхөн ажлын цагаар ажиллах. Насанд хүрээгүй хүүхдэд үйлчлэх, хотын хөдөлгөөн ихтэй бүсэд үйлчилгээ явуулахыг хориглох. Ломбардаар дамждаг хулгайн эд зүйлийг таслан зогсоохын тулд нэгдсэн мэдээллийн сан боловсруулж цахимжуулахаар тусгасан байдаг. Учир нь тайлан тооцоо нь ихэвчлэн далд байдаг барьцаалан зээлдүүлэх үйлчилгээнд жилд дунджаар 30 гаруй тэрбум төгрөг эргэлддэг. Үүний 7-8 тэрбум нь хулгайн эд зүйл байдаг аж.

Гэвч энэ чихэнд чимэгтэй журам үйлчлээд бараг хоёр сарын хугацаа өнгөрөх гэж бай-

гаа ч хэрэгжилт нь сул хэвээр. Дийлэнх барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ эрхлэгч уг журмыг хэрэгжүүлэх нь бүү хэл сонсож, дуулаагүй явна. Энхтайваны өргөн чөлөө буюу бидний нэрлэж заншсанаар МУБИС-ийн автобусны буудлын дэргэдэх "Хурд II" ломбард эрхлэгч уг журамтай танилцаагүй. "Зурагтаар шинэ журмын талаар мэдээ сонссон. Гэхдээ үзэж, хараагүй" хэмээн тус ломбардад суугаа залуу бүсгүй хэлэв. Бид энэ орчмын хэд хэдэн ломбардын зориход нөхцөл байдал яг адил байлаа.

Дур зоргоороо авирладаг барьцаалан зээлдүүлэх үйлчилгээнүүдэд улаан гэрэл болох шинэ журам хэрэгжиж эхлээгүй байна. Учир шалтгааныг холбогдох байгууллагуудаас асуулаа.

Гэвч хэрэгжүүлэхийг шаардах, хяналт тавих учиртай байгууллагууд арьсаа хамгаалсан, бие бие рүүгээ чихсэн хариулт хэлж байна.

Тухайлбал, холбогдох шинэчлэлийн хүрээнд хулгайн эд зүйл дамжуулахыг таслан зогсоохын тулд цахим мэдээллийн сан үүсгэхээр болсон. Энэ сангийн үйл ажиллагааг идэвхжүүлж, хэрэгжилтийг хангах үүргийг нийслэлийн Цагдаагийн газар болон Үндэсний Дата төв хариуцахаар болсон. Цагдаагийн байгууллагаас харьяа дүүргийн ломбардуудад хяналт, шалгалт хийж, холбогдох техник хэрэгсэлээ бэлдэхийг сануулснаа Баянгол дүүргийн Цагдаагийн нэгдүгээр хэлтсээс мэдээлэв.

Гэвч өнөөг хүртэл нэгдсэн систем идэвхжээгүй л байна.


Тэрчлэн ломбардууд "биднийг хэн хянахав" гэсэн шиг үүргээ гүйцэтгэж яваа албан хаагчдыг тоодоггүй болохыг зарим нь учирлав.

Үүнээс гадна цагийн хуваарь, үйлчилгээний чанарыг сайжруулахад харьяа дүүргийн Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс хамтран ажиллах үүрэгтэй. Гэвч "Бид хэлтэс хянаж, шалгах үүрэгтэй байгууллага биш. Манай мэргэжилтнүүдэд торгох эрх байхгүй. Харин аль болох иргэд үйлчилгээ эрхлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой. Бид дээрээс өгсөн стандарт, шаардлагыг тавьдаг. Гэхдээ стандартад бол хууль биш. Материалаа бүрдүүлээд ирсэн хуулийн этгээдэд үгүй гэж хэлэх эрх бидэнд байхгүй" гэж Баянзүрх дүүргийн Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн хэлж байв.

Ингэж хяналт тавих, сурталчлах үүрэгтэй холбогдох байгууллагууд үүрэг хариуцлагаас хөндийрөн, чиг үүргээ бие бие рүүгээ чихсэнээр итгэл дагуулж байсан дүрэм журам хөсөр хаягдахад хүрээд байна. Энэ зуур бичил санхүүгийн бизнес эрхлэгчид зохицуулалтын шинэчлэлийг тоолгүй том толгойлж, иргэдийг ч, албаныхныг элэг барьж сууна.

Уг нь энэ чиглэлийн зохицуулалтыг цэгцлэх, мөнгө хүүлэгчдийн хүлээсийг суллах, монголчууд сул чөлөөтэй амьсгалах боломж олгох алхмуудыг албаныхан 2014 оноос хойш хийж үргэлжлэн хэрхэн маргагдаж, завхарсаар өнөөгийн нөхцөлд байдалд хүргэчихээд байгаа юм. Энэ жишгээр бол үйлчлээд удаагүй шинэ журам ч цаасан дээр үлдэж мэдэхээр байна. Төрийн тогтоосон хууль журманд тоомжиргүй ханддаг даврагсад дагуулаа гэдгийг мэдүүлж, дүрэм журам сахиулахын тулд холбогдох байгууллагууд тууштай ажиллах шаардлагатай байна. [ЗГМ]

Алтны ханш унав



Дэлхийн тэргүүлэх эдийн засаг АНУ-ын төв банк хурлын тэмдэглэлээ ил болголоо. Тус тэмдэглэлд Америкийн эдийн засгийн нөхцөл байдал харьцангуй сайн байгааг дурдсан.

Энэ нь ам.долларын ханштай урвуу хамааралтай алтны ханшид дарамт болов. Тус металлын ханш пүрэв гарагт 0.1 хувиар буурч, унц нь 1323.18

ам.доллартай тэнцсэн байна. Ингэснээр алтны ханш энэ сарын 15-наас хойш тасралтгүй суларч байна.

Алтнаас гадна газрын тосны ханш буурсан. Тухайлбал, АНУ-ын газрын тосны жишиг болох West Texas төрлийн түүхий эдийн үнэ 0.7 хувиар буурч, баррель нь 61 ам.долларт хүрлээ. Энэ нь сүүлийн таван өдрийн доод цэг юм. [ЗГМ]

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ СОНИН
Эдийн засаг, уул уурхайн цогц мэдээллийн ертөнцөд таныг урьж байна

Онлайн захиалга
• Улиралд: 5000Т (62 дугаар)
• Хагас жилд: 10 000Т (124 дугаар)
• Жилд: 15 000Т (248 дугаар)

QR кодыг уншуулан гүйлгээний утга хэсэгт и-мэйл хаяг эсвэл утасны дугаараар бүртгүүлэн Засгийн газрын мэдээ сонинг өөрийн хүссэн хэлбэрээрээ захиалаарай.

УЛААНБААТАР ХОТЫН БАНК
2600079789
ТООТ ДАНСАНД МӨНГӨӨ ТУШААНА УУ.

МОНГОЛД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ ГАДААД КОМПАНИУД						
НЭР	СИМБОЛ	БИРЖ	ВАЛЮТ	ХАНШ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
RIO TINTO	RIO	ASX	AUD	80.12	▼ -0.17%	2/22/2018
WOLF PETROLEUM	WOF	ASX	AUD	0.014	▼ -17.65%	2/22/2018
PETRO MATAD	MATD	LON	GBX	9.4	▼ -1.05%	2/22/2018
ASPIRE MINING	AKM	ASX	AUD	0.009	▼ -10%	2/22/2018
GUILDFORD COAL	GUF	ASX	AUD	0.013	▼ -7.69%	2/22/2018
PROPHECY DEVELOPMENT	PCY	TSX	CAD	3.09	▼ -0.32%	2/22/2018
TURQUOISE HILL RESOURCES	TRQ	TSX	CAD	3.5	▼ -2.23%	2/22/2018
SOUTHGOBI RESOURCES	SGQ	TSX	CAD	0.18	▲ 2.86%	2/22/2018
KANADU MINES	XAM	ASX	AUD	0.56	▲ 7.69%	2/22/2018
ENTREE GOLD	ETG	TSX	CAD	0.24	▼ -4.17%	2/22/2018

ТҮҮХИЙ ЭД					
НЭР	СИМБОЛ	НЭГЖ	ХАНШ (\$)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
АЛТНЫ СПОТ	XAU	унци	1322.35	▼ -0.17%	2/22/2018
ЦАГААН АЛТ	PLA	унци	990.9	▼ -0.57%	2/22/2018
МӨНГӨ	SIA	унци	16.435	▼ -1.46%	2/22/2018
ЗЭС (СОМЕХ)	HGA	фунт	318.15	▼ -1.71%	2/22/2018
ТӨМРИЙН ХҮДЭР	TIOA	тонн	77.18	▲ 0.27%	2/22/2018
WTI ТОС	CLA	баррель	61.11	▼ -0.92%	2/22/2018
БРЕНТ	COA	баррель	64.9	▼ -0.79%	2/22/2018
БЕНЗИН	XBA		174.58	▼ -0.65%	2/22/2018
БАЙГАЛИЙН ХИЙ	NGA	Mmbtu	2.645	▼ -0.53%	2/22/2018
НҮҮРС (NYMEX)	QZA	тонн	336.55	▲ 0.21%	2/22/2018
НҮҮРС (NEW CASTLE)	XWA	тонн	103.15	▲ 0.29%	2/22/2018
ЭЛСЭН ЧИХЭР	SBA	фунт	13.31	▲ 0.30%	2/22/2018
БУДАА	RRA	центнер	11.96	▲ 0.89%	2/22/2018
БУУДАЙ	WA	бушель	457.5	▼ -0.44%	2/22/2018
КАКАО	CCA	тонн	2173	▲ 1.16%	2/22/2018
КОФЕ	KCA	фунт	118.9	▼ -0.67%	2/22/2018

Энэхүү ханшийн мэдээлэл нь хүснэгтэд заасан өдрийн 15 цагийн байдлаарх дүн тул үүнээс хойш өөрчлөгдсөн байх боломжтой.

MEDIA SCREEN
Bloomberg TV Mongolia

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ				
НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
АПУ ХК	APU	673.79	▼ -3.18%	2/22/2018
ГОВЬ ХК	GOV	23020	▼ -3.36%	2/22/2018
МАХ ИМПЕКС ХК	MMX	2631	▼ -7.36%	2/22/2018
МОНГОЛ ШУУДАН ХК	MNP	598	▼ -0.33%	2/22/2018
СҮҮ ХК	SUU	201.88	▲ 0.39%	2/22/2018
ТАВАНТОЛГОЙ ХК	TTL	10050	▼ -9.70%	2/22/2018
АДУУН ЧУЛУУН ХК	ADL	2900	◄ 0%	2/22/2018
БАГАНУУР ХК	BAN	1901	▼ -4.90%	2/22/2018
БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ ХК	BNG	33500	▼ -6.89%	2/22/2018
УБ-БУК ХК	BVK	400	▼ -5.88%	2/22/2018
Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК	ETR	85	◄ 0%	2/22/2018
ГУТАЛ ХК	GTL	19510	▲ 0.52%	2/22/2018
ГЕРМЕС ЦЕНТР ХК	HRM	140	▼ -6.04%	2/22/2018
АЙТҮҮЛС ХК	ITLS	128.34	▼ -0.06%	2/22/2018
ЖЕНКО ТҮР БҮРЯ ХК	JTB	67	▼ -0.01%	2/22/2018
МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК	MCH	520	▼ -5.28%	2/22/2018

Тухайн өдөр арилжаалагдсан хувьцаа

ДЭЛХИЙН ГОЛЛОХ ИНДЕКСҮҮД					
НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
NASDAQ COMPOSITE	CCMP	7218.227	-16.08	▼ -0.22%	2/22/2018
DAX INDEX	DAX	12307.1	-163.39	▼ -1.31%	2/22/2018
TORONTO STOCK EXCHANGE	SPTSX	15524.01	+84.57	▲ +0.55%	2/22/2018
S&P/ASX 200	AS51	5950.881	+7.16	▲ +0.12%	2/22/2018
S&P 500	INX	2701.33	-14.93	▼ -0.55%	2/22/2018
SHANGHAI COMPOSITE	SHCOMP	3268.559	+69.4	▲ +2.17%	2/22/2018
DOW JONES INDUSTRIAL AVERAGE	INDU	24797.78	-166.97	▼ -0.67%	2/22/2018
TOP 20	MSETOP	20001.38	-699.18	▼ -3.38%	2/22/2018
FTSE 100	UKX	7207.33	-74.24	▼ -1.02%	2/22/2018
HANG SENG	HSI	30965.68	-466.21	▼ -1.48%	2/22/2018
NIKKEI 225	NKY	21736.44	-234.37	▼ -1.07%	2/22/2018